

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭН ДЭХ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ СУДАЛГАА

УИН МН  
СУДАЛГААНЫ САН

---

*Монгол Улсад засаглал,  
ил тод байдлыг дэмжих  
хөтөлбөр*

2014 оны 6 сар



**The Asia Foundation**

Энэхүү судалгааг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-аас үзүүлсэн Америкийн ард түмний өгөөмөр дэмжлэгтэйгээр хийсэн болно. Судалгааг АНУ-ын Азийн сан, Хараат Бус Судалгааны Хүрээлэн, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар хамтран явуулсан бөгөөд судалгаа нь АНУ-ын Засгийн газар болон ОУХА-ын үзэл бодлыг илэрхийлээгүй болохыг анхаарна уу.

---

## ГАРЧИГ

---

|  |          |
|--|----------|
| ТАЛАРХАЛ   | 2        |
| ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР  | 3        |
| 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ   | 4        |
| 1.1 Судалгааны үндэслэл  | 4        |
| 1.2 Судалгааны зорилго, зорилт   | 4        |
| 1.3 Судалгааны арга  | 5        |
| 1.4 Судалгааны түүвэрлэлт  | 6        |
| 1.5 Судалгааны хэрэглэгдэхүүний хэлэлцүүлэг<br>болон сургалт, туршилт судалгаа | 8        |
| 1.6 Судалгааны мэдээлэл дэх чанарын хяналт                                     | 9        |
| 1.7 Судалгааны хязгаарлагдмал тал  | 10       |
| 1.8 Нөхцөл байдал  | 10       |
| 2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ                                     | 14       |
| 2.1 Үйлчлүүлэгчийн ажил эрхлэлтийн байдал                                      | 16       |
| 2.2 Эмч, сувилагчийн ажил эрхлэлтийн байдал                                    | 17       |
| 2.3 Судалгаанд оролцогчдын орлогын байдал                                      | 20       |
| 2.4 Үйлчлүүлэгчийн авсан үйлчилгээний талаарх мэдээлэл                         | 22       |
| 3. АЖИГЛАЛТ  | 24       |
| 4. ОЙЛГОЛТ БА ХАНДЛАГА   | 27       |
| 5. ХУВИЙН ТУРШЛАГА   | 31       |
| 5.1 Үйлчлүүлэгчийн хувийн туршлага   | 31       |
| 5.2 Эмч, сувилагчийн хувийн туршлага   | 36       |
| 6. ШАЛТГААН НӨХЦӨЛ   | 40       |
| 7. САНХҮҮГИЙН НӨЛӨӨЛӨЛ   | 46       |
| 8. АХ ДҮҮ, ТАНИЛ ТАЛАА АШИГЛАХ<br>ДҮГНЭЛТ                                      | 49<br>51 |
| ХАВСРАЛТ 1 СУДАЛГААНЫ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН                                       | 53       |
| ХАВСРАЛТ 2 СУДАЛГААНЫ АСУУМЖ   | 59       |
| ХАВСРАЛТ 3 СУДЛАГДСАН БАЙДАЛ   | 75       |

---

## ТАЛАРХАЛ

---

“Эрүүл мэндийн үйлчилгээн дэх авлигын нөхцөл байдал”-ын судалгааг Азийн сангийн захиалгаар Хараат Бус Судалгааны Хүрээлэн 2014 оны 3-р сараас 6 сард хийж гүйцэтгэв.

Уг судалгааг санаачилсан, санхүүжүүлсэн мөн зохион байгуулахад гүн туслалцаа үзүүлсэн АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Азийн сангийн Засаглал, ил тод байдлыг дэмжих төсөл судалгаа явуулахад хамтран ажилласан Авлигатай тэмцэх газар, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн эрүүл мэндийн газар болон тэдгээрийн харьяа эрүүл мэндийн байгууллагын эмч, сувилагч, үйлчлүүлэгч нарт талархал илэрхийлж байна.

Судалгааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах болон санал хүсэлтээ өгөхийг хүсвэл Азийн сан болон Хараат бус судалгааны хүрээлэнтэй холбогдоно уу.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

|        |   |
|--------|---|
| ЭМЯ    | Эрүүл Мэндийн яам                               |
| АТГ    | Авлигатай Тэмцэх Газар                          |
| НЭМГ   | Нийслэлийн Эрүүл Мэндийн Газар                  |
| МУИС   | Монгол Улсын Их Сургууль                        |
| АНУ    | Америкийн Нэгдсэн Улс                           |
| ОУХА   | Олон Улсын Хөгжлийн Агентлаг                    |
| НҮБХХ  | Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр |
| УНТЭ   | Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг                     |
| УХТЭ   | Улсын Хоёрдугаар Төв Эмнэлэг                    |
| УГТЭ   | Улсын Гуравдугаар Төв Эмнэлэг                   |
| ГССҮТ  | Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв              |
| ХСҮТ   | Хавдар Судлалын Үндэсний Төв                    |
| ХӨСҮТ  | Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв            |
| ЭХЭМҮТ | Эх Хүүхэд Эрүүл Мэндийн Үндэсний Төв            |
| КНАГ   | Клиникийн Нэгдүгээр Амаржих Газар               |
| КХАГ   | Клиникийн Хоёрдугаар Амаржих Газар              |
| КГАГ   | Клиникийн Гуравдугаар Амаржих Газар             |
| СХД    | Сонгинохайрхан дүүрэг                           |
| БГД    | Баянгол дүүрэг                                  |
| БЗД    | Баянзүрх дүүрэг                                 |
| УБ     | Улаанбаатар                                     |
| ОУБ    | Олон Улсын Байгууллага                          |
| ТББ    | Төрийн Бус Байгууллага                          |

## 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### 1.1 Судалгааны үндэслэл

Олон нийтийн дунд авлига нь анхаарал татсан асуудлын нэг билээ. Тэр дундаа эрүүл мэндийн үйлчилгээний ил тод байдал болоод эмч, сувилагчийг авлига авдаг гэх цуурхал олон нийтийн дунд ихээхэн тархсан байдаг хэдий ч нарийвчилсан мэдээлэл нотолгоо байхгүй байна.

Азийн сан нь Сант Марал сантай хамтарч “Авлигын талаарх олон нийтийн ойлголт мэдлэг тогтоох судалгаа”-г хагас жил 1 удаа хийсээр ирсэн билээ. Энэхүү судалгаанд салбар бүрийн авлигын тархалтыг судалсан хэдий ч салбар тус бүрийг нарийвчлан судлаагүй байна.

Эрүүл мэндийн салбар дахь авлигын нөхцөл байдлыг олон нийтэд нээлттэй байлгахад бодлого боловсруулагчдын анхаарлыг хандуулах нь зүйтэй учраас эрүүл мэндийн үйлчилгээн дэх авлигын хэлбэр, хэмжээ, шалтгаан, үр дагаврыг судлах хэрэгцээ үүсэж байна.

Тиймээс АНУ-ын ОУХА-ын санхүүжилтээр Азийн сангаас хэрэгжүүлж байгаа “Засаглал -Ил тод байдлыг дэмжих” төслийн хүрээнд Эрүүл мэндийн үйлчилгээн дэх авлигын нөхцөл байдлыг тодорхойлох судалгааг хийж гүйцэтгэх болсон.

“Эрүүл мэндийн үйлчилгээн дэх авлигын нөхцөл байдал”-ын судалгаа нь Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагуудыг түүвэрлэн сонгож, үйлчилгээ үзүүлж буй эмч, сувилагч, тэдгээр байгууллагаар үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийг хамарснаараа онцлогтой юм.

### 1.2 Судалгааны зорилго, зорилт

Эрүүл мэндийн салбарын эмч, сувилагчдад үйлчлүүлэгчдээс бэлэг сэлт, мөнгө өгч байгаа өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, асуудлыг хэлэлцүүлэх, нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлс, шалтгааныг зураглаж үйлчилгээний ачаалал ба бэлэг сэлт өгч, авч байгаа байдал хоорондоо уялдаа холбоотой байгаа эсэхийг тодорхойлох нь судалгааны гол зорилго юм. Уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Иргэд эрүүл мэндийн үйлчилгээг хуульд заасан стандартын дагуу авахад үйлчилгээний үндсэн төрөл ба түвшинд саад болж байгаа бэлэг сэлт, мөнгө өгч буй тохиолдлыг тэдний туршлага дээр тулгуурлан гаргаж ирэх;

2. Эмч, сувилагч нар үйлчилгээ үзүүлэхдээ бэлэг сэлт, мөнгө авах болсон үндсэн хүчин зүйлийг тодорхойлох;
3. Үйлчлүүлэгчийн тогтсон хандлагыг (бэлэг сэлт, мөнгө авах тухай ойлголт, хандлага) үнэлэх;
4. Судалгааны үр дүнгээр эрүүл мэндийн салбарын хэлэлцүүлгийг эхлүүлэх.

### 1.3 Судалгааны арга

Бид судалгаандаа үйлчлүүлэгчдээс 32 асуулт (Хавсралт 2) бүхий асуумж, эмч, сувилагчдаас 29 асуулт (Хавсралт 3) бүхий хагас бүтэцчилэгдсэн ярилцлага авав. Мөн кейс судалгааны арга, баримт бичгийн судалгааг ашиглав. *Хүснэгт*

#### 1. Судалгааны арга

| Арга                           | Ерөнхий зорилтот бүлэг   | Зорилго   |
|--------------------------------|--|---|
| Хагас бүтэцчилэгдсэн ярилцлага | 1. Эмч<br>2. Сувилагч  | Энэ аргын тусламжтайгаар судалгаанд оролцогчоос сэдвийн хүрээнд илүү дэлгэрэнгүй мэдээллийг авахаас гадна бусад асуумжтай харьцуулалт хийх гол зорилготой байв.     |
| Асуумж                         | 1. Үйлчлүүлэгч<br>2. Өрхийн гишүүн (эхнэр, нөхөр, хүүхэд, төрсөн ах, эгч, дүү, аав, ээж, эмээ, өвөө) | Эмч сувилагч ба үйлчлүүлэгчийн хувьд бэлэг сэлт, мөнгөтэй холбоотой хичнээн тохиолдол гарсныг шинжлэн үзэв.   |
| Кейс судалгаа                  | 1. Бэлэг өгч байсан үйлчлүүлэгч  | Эрүүл мэндийн салбарын авлигын нөхцөл байдлыг тайлбарлах, дүр зураг буулгахад энэхүү аргыг ашигласан.   |
| Баримт бичгийн судалгаа        | 1. Эрүүл мэндийн статистикийн баримт бичиг<br>2. Авлигын түвшин тогтоох судалгааны тайлангууд        | Энэ аргын тусламжтайгаар эрүүл мэнд болон авлигын талаарх үндсэн ойлголтыг нэгтгэн дүгнэхэд чиглэнэ. Мөн авлигын талаарх нөхцөл байдлын шинжилгээ хийхэд ашигласан. |

## 1.4 Судалгааны түүвэр

### Судалгааны түүврийн хэмжээ

Судалгаа нь Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 1,2,3-р шатлалын эмнэлгүүдийг төлөөлөх чадвартайгаар 18 эмнэлэг сонгосон. 2012 оны байдлаар Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын амбулаториор үйлчлүүлэгчдийн нийт тооноос мэдээлэл цуглуулах 14 хоногт үйлчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоог бодож эдгээр үйлчлүүлэгчдийн төлөөлөх чадварыг тооцоолон түүврийн хэмжээг тогтоов.

Эмч, сувилагчийн түүврийн хэмжээг сонгохдоо 2012 онд Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн байгууллагын нийт эмч, сувилагчийн тооноос түүврийн хэмжээг тогтоов. Эмч, сувилагчаас чанарын аргаар судалгааны мэдээлэл цуглуулсан хэдий ч төлөөлөх чадварын хувьд хангалттай хэмжээг тооцоолсон.

Тоон судалгааны түүврийн хэмжээг дараах томъёоны дагуу тооцоолсон:

$$n = \frac{Z^2 * p * (1-p)}{C^2}$$

Энд, Z-стандарт хэвийн тархалтын утга (95 % итгэх түвшинтэй үед 3.7 байна), p=тухайн хувилбарын сонгогдох магадлал (эх олонлогийн стандарт хазайлт мэдэгдэхгүй үед түүврийн хэмжээг олохдоо бид хамгийн багаар бодож 0.5 гэж авна), C - итгэх завсар, (0.05 буюу ±5%). Параметруудийг дээрх

утгатайгаар тооцвол, хангалттай түүврийн хэмжээ 699 байна.

Сонгогдсон эмнэлгийн эмч, сувилагч нараас нийт 367 хандалт хийн 200 эмч, сувилагчийг судалгаанд хамруулсан. Харин үйлчлүүлэгчдээс 1206 хандалтийг хийн 700 үйлчлүүлэгчийг судалгаанд хамруулсан.

Эмнэлгийн тасаг, кабинетуудыг сонгохдоо эмнэлэг тус бүрт үндсэн үйлчилгээ үзүүлдэг тасаг, кабинетуудыг жигд хамруулахыг хичээв.

Ингэхдээ төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч ажилладаггүй эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг кабинетуудыг /шинжилгээний, сувилахуйн гэх мэт/ хассан. Эмнэлгийн тасаг кабинетийг сонгохын тулд эмнэлгийн байгууллагуудын дотоод бүтэц, зохион байгуулалтыг нарийвчлан судалсан. Сонгогдсон тасаг кабинетуудаас эмч, сувилагчийн тоог жигд харьцаатай сонгосон.



## Хүснэгт 2. Судалгааны түүвэрлэлт

| №  | Байршил                            | Үйлчлүүлэгч | Эмч | Сувилагч | Нийт |
|----|------------------------------------|-------------|-----|----------|------|
| 1  | Улсын нэгдүгээр төв эмнэлэг        | 53          | 9   | 8        | 70   |
| 2  | Улсын хоёрдугаар төв эмнэлэг       | 53          | 9   | 7        | 69   |
| 3  | Улсын гуравдугаар төв эмнэлэг      | 53          | 9   | 7        | 69   |
| 4  | ГССҮТ                              | 53          | 9   | 8        | 70   |
| 5  | ХСҮТ                               | 53          | 9   | 7        | 69   |
| 6  | ХӨСҮТ                              | 53          | 9   | 7        | 69   |
| 7  | ЭХЭМҮТ                             | 53          | 9   | 8        | 70   |
| 8  | Клиникийн нэгдүгээр амаржих газар  | 53          | 8   | 7        | 68   |
| 9  | Клиникийн хоёрдугаар амаржих газар | 53          | 9   | 7        | 69   |
| 10 | СХД-ийн ЭМН                        | 54          | 8   | 4        | 66   |
| 11 | БГД-ийн ЭМН                        | 55          | 5   | 4        | 64   |
| 12 | БЗД-ийн ЭМН                        | 50          | 5   | 4        | 59   |
| 13 | БГД-ийн 5,18-р хороо               | 20          | 4   | 4        | 28   |
| 14 | БЗД-ийн 2,15-р хороо               | 22          | 4   | 4        | 31   |
| 15 | СХД-ийн 6,19-р хороо               | 22          | 4   | 4        | 30   |
|    | Нийт                               | 700         | 110 | 90       | 900  |

Сонгогдсон эмнэлгийн байгууллагууд дээрээс судалгаанд оролцогчдыг сонгохдоо доорхи шалгуурыг баримталсан.

#### **Судалгаанд оролцсон үйлчлүүлэгч:**

1. 18-аас дээш настай Монгол улсын иргэн байх,
2. Үйлчлүүлэгч нь (эсвэл өрхийн гишүүн<sup>1</sup>) эмнэлгээр сүүлийн 1 жилийн дотор үйлчлүүлсэн байх,
3. Судалгаа авч байх үед тухайн эмнэлгээр өөрөө (эвсэл өрхийн гишүүн) үйлчлүүлж байсан,

#### **Судалгаанд оролцсон эмч, сувилагч:**

1. Эмч, сувилагчийн мэргэжил эзэмшсэн байх
2. Тухайн эмнэлэгт 1-ээс доошгүй жил ажилласан байх

#### **Кейс судалгаанд оролцох үйлчлүүлэгч:**

1. Тухайн үйлчлүүлэгч (эсвэл өрхийн гишүүн) нь тус эмнэлгийн бүх шат дамжлагаар дамжсан буюу үзлэг, шинжилгээ, мэс засал гэх мэт бүх үйлчилгээнд хамрагдсан байх,
2. Түүвэрт орсон аль нэг эмнэлгийн байгууллагын эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгсөн байх

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа дараах зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- Судалгаанд үйлчлүүлэгч болон эмч, сувилагчийг хамруулахын өмнө зөвшөөрлийн хуудсыг уншуулж судалгаанд оролцогчоос зөвшөөрөл авсан.
- Судалгаанд оролцогчийн хариултын нууцлалыг Монгол улсын “Статистикийн тухай”, “Хувь хүний нууцын тухай” хуулиудын дагуу бусдад задруулахгүйгээр чандлан хадгална.
- Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчийн өвчний түүхтэй холбоотой нарийвчилсан мэдээллийг асуугаагүй.

### **1.5 Судалгааны хэрэглэгдэхүүний хэлэлцүүлэг болон сургалт, туршилт судалгаа**

1. Судалгааны хэрэглэгдэхүүн боловсруулах шатанд Азийн сан болон АТГ-т хэрэглэгдэхүүний саналыг явуулж нарийвчлан хэлэлцүүлсэн.
  - 1.1. АТГ-ын асуудал хариуцсан ажилтантай холбогдож хэрэглэгдэхүүн боловсруулах шатанд санал авсан.

<sup>1</sup> Өрхийн гишүүн гэдэгт аав, ээж, эмээ, өвөө, эхнэр, нөхөр, төрсөн ах, төрсөн эгч, төрсөн дүү зэргийг тооцов.

- 1.2. Хараат бус судалгааны хүрээлэнгийн төслийн баг хэрэглэгдэхүүн эцэслэх шатанд Азийн сангийн Засаглалын хөтөлбөрийн менежертэй нягт холбоотой ажилласан, албан ёсоор Азийн сангаас 2 удаагийн санал авч хэрэглэгдэхүүнийг сайжруулсан.
2. Судлаачдын сургалт: Сургалтаар мэдээлэл цуглуулах шатанд ажиллах судлаачдад судалгааны зорилго, хүрээ, авлигын талаарх ерөнхий мэдээлэл, эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо, үйлчилгээний төрлүүд, судлаачдын зарчим, хэрэглэгдэхүүний талаар нарийвчилсан зааварчилгааг өгсөн.
3. Туршилт судалгааны үр дүнд: Бэлэн болсон хэрэглэгдэхүүнийг талбарын судлаачид туршиж үзэж, үйчлүүлэгчийн асуумжийн 30 хувьд, эмч, сувилагчийн хагас бүтэцчилсэн ярилцлагын агуулгын 20 хувьд өөрчлөлт хийж нэмж засварлан сайжруулсан.

## 1.6 Судалгааны мэдээллийн чанарын хяналт

Судалгааны мэдээлэлд чанарын хяналт тавих чухал байв. Мэдээллийн чанарын хяналт нь дараах үе, шатаас бүрдсэн. Үүнд:

1. Талбарын хяналт
2. Агуулгын хяналт
3. Утсан хяналт
4. Шивэлт
5. Шивэлтийг хянах зэрэг болно.

### 1. Талбарын хяналт

Талбарын хяналтын үндсэн зорилго нь түүвэрлэлт болон шалгуурын дагуу судалгаанд оролцогчдыг сонгож байгаа эсэхийг хянах юм. Талбарын хяналтын явцад судлаачид ёс зүйн дагуу өөрсдийгөө танилцуулж респондентоос судалгаа авах зөвшөөрлийг аван асуултыг бүрэн гүйцэт асууж байгаа эсэхийг хянав. Талбарын хяналт 30 хувьд нь хийгдсэн.

### 2. Агуулгын хяналт

Агуулгын хяналтын үндсэн зорилго нь цугларсан мэдээллийг тухай бүрт нь хүлээн авч, асуумж тус бүрийн асуулт нэг бүрийг нь зааварчилгааны дагуу бөглөсөн эсэхийг хянах юм. Агуулгын хяналт 100 хувь хийгдсэн. Агуулгын хяналтын алдааг судалгаанд оролцогчтой эргэн холбогдож засварласан.

### 3. Утсан хяналт

Тухайн судлаач түүвэр, зорилтот бүлгээс (оролцогчоос) судалгаа авсан эсэхийг утсан хяналтаар шалгаж тогтоож байсан. Утсан хяналт 100 хувь хийгдсэн, утсан хяналтанд ороод хүчинтэйд тооцогдсон асуумж бүрийг шивсэн.

#### 4. Шивэлт

Агуулгын хяналт, утсан хяналтаар орж алдаагүйд тооцогдсон асуумжийг компьютерийн эксел программд шивж оруулав.

#### 5. Шивэлтийн хяналт

Шивэлтийн хяналтын гол зорилго нь мэдээлэл оруулах ажил алдаагүй явагдсан эсэхийг хянах юм. Уг хяналт нийт асуумжийн 50 хувьд хийгдсэн болно.

### 1.7 Судалгааны хязгаарлагдмал тал

**Агуулгын хувьд** Авлига, шан харамж, хээл хахууль, нэмэлт төлбөр, гэсэн өргөн хүрээтэй асуудлыг бүгдийг нь хамруулж үзэлгүйгээр хуульд заасны дагуу бэлэг гэдэг ойлголт дээр төвлөрч судалгааг хийсэн.

**Мэдээлэл цуглуулалтын хувьд** Эмч, сувилагч нар ажлын ачаалал болоод судалгааны сэдвээс шалтгаалан судалгаанд оролцохоос татгалзах тохиолдол гарч байсан. Тиймээс судалгааны цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас үүдээд зарим тохиолдолд хамт ажиллагсад болон дээд албан тушаалтнаар нь дамжин холбогдож эмч, сувилагч нарыг судалгаанд оролцуулсан.

### 1.8 Нөхцөл байдал

**Төрийн байгууллагын нээлттэй ил тод байдлын мониторинг (2007).** Судалгааны үр дүнгээр эрүүл мэндийн салбарын мэдээллийн нээлттэй ил тод байдал харьцангуй тааруу үзүүлэлттэй байгууллагын нэг байсан. Эрүүл мэндийн салбарын байгууллагын төсвийн нээлттэй байдал 33,3 хувь, албан хаагчийн мэдээлэл /хөрөнгө орлогын мэдүүлэг гэх мэт/ 22,2 хувьтай, судалгаанд хамрагдсан иргэдээс эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн 20 хувь нэмэлт төлбөр хураамж төлсөн байна.

**2007 онд хийгдсэн “Эрүүл мэндийн салбар дахь авлига ба шудрага ёсны өнөөгийн байдал”** Уг судалгаагаар гар цайлгалт, нэмэлт төлбөр, авлига, хээл хахуулийн талаар олон талт үзэл бодлын ялгааг харьцуулж гаргаж ирсэн байна. Эрүүл мэндийн салбарт авлига байгаа гэдгийг тус судалгааны үр дүнгээс харж болох бөгөөд судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдийн 36 хувь, эмч, эмнэлгийн ажилтны 80 хувь нь ямар нэг хэмжээгээр албан бус төлбөр байх ёстой гэж үзсэн байна.

**Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, эмнэлгийн мэргэжилтний байгууллагаас гадуурх ажил эрхлэлт (2013 он).** Эмнэлгийн удирдах албан тушаалтнуудад өөрсдийн танил талд илүү эмчилгээ хийх байдал их, санхүүгийн тайлангаа ил тод тавьдаггүй дутагдал түгээмэл байна. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд өөрийн мэргэжлээр ажлын бус цагаар, хувийн байгууллагуудад, өөрийн үндсэн ажилтай адил давхар ажил эрхлэх байдал цөөнгүй байна.

**Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа (2013 он).** Эрүүл мэндийн салбар 3,43 оноогоор /огт байхгүй-1, маш их-5/авлигад өртөх эрсдэл өндөртэй байгууллагуудаас 14-р байранд байсан бол байсан бол 2013 оны 9 сарын байдлаар 3,45 болж 12-р байр болж урагшилсан нь иргэдийн дунд эрүүл мэндийн салбар дахь авлига нь тогтвортой бууруурахгүй үзүүлэлттэй байгааг харж болохоор байна.

**Авлигын индексийн 2013 оны судалгааны үр дүнгийн тайлан.** Шинжээч, олон нийтийн үзсэнээр улс төрийн нөлөө болон ашиг сонирхлын зөрчил их, төрийн албан хаагчдын цалин, орлого бага, эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул байгаа нь Монгол улсад авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж буй шалтгаан болж байна.

Эрүүл мэндийн салбар дахь авлигын судалгааны ажил нь дээрх судалгаануудын нэг хэсэг нь болон хийгдсэн байна. Тухайлсан эрүүл мэндийн үйлчилгээн дэх авлигын нарийвчилсан судалгаа хийгдээгүй байна.

#### **Төслийн хүрээнд судалсан баримт бичгийн жагсаалт**

**Эрүүл мэндийн тухай хууль** - Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төрөл, эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг, хүлээлгэх хариуцлага зэргийг илүү судалж энэхүү хүрээнд судалгааг явуулсан. Энэ хуулийн үйлчлэлийн дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээний төрлийг сонгон 3 шатлал бүрээс эмнэлгүүдийг түүвэрлэн хамруулсан. Мөн судалгаанд хэрэглэх эмнэлгийн салбартай холбогдох гол нэр томъёог ашигласан.

**Монгол Улсын Засгийн Газрын 2010 оны 288-р тогтоол: Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм** - Энэ нь төрийн албан хаагчийн нийтлэг дагах жишиг ёс зүйн дүрэм тул энэхүү ёс зүйн дүрэмд эмч, сувилагчийн ажил, үйлчилгээний ёс зүй бүрэн хамаарах юм. Энэхүү ёс зүйн дүрэмд зааснаар шударга ёсны, хууль дээдлэх, тэгш байх, хариуцлага хүлээх, олон нийтэд үйлчлэх зарчмыг үйл ажиллагаандаа баримтална гэжээ.

**Монгол Улсын төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйл: Төрийн албаны үндэсний чуулган** - Тус чуулганаар төрийн албан хаагчийн эрхэмлэх есөн зүйлийг “ёс зүйг эрхэмлэнэ”, “шударга ёсыг эрхэмлэнэ” гэх мэт ёс зүйн хэм хэмжээг баталсан нь одоо төрийн албан хаагчид баримтлан үйлчилгээ үзүүлж байна.

**Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ: Эрүүл мэндийн сайдын 2013 оны 446-р тушаал** - Энэхүү ёс зүйн хэмжээг эрүүл мэндийн байгууллага, түүний ажилтнууд мөрдөн ажиллах ёстой. Ёс зүйн хэм хэмжээний 3.25-р зүйлд “Эмнэлгийн мэргэжилтэн нь эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлснийхээ төлөө үйлчлүүлэгчээс авлига, хууль бус шан

харамж, хандив, бэлэг, албан бус төлбөр авахгүй ба үйлчлүүлэгчтэй давхар харилцаанд орохгүй байх” гэдгийг маш тодорхой заасан байна.

**Авлигын эсрэг хууль** - Авлигын эсрэг хуулиас судалгаанд ашиглах гол нэр томъёог тодруулах, тэдгээрийн үйлчлэх хүрээг тодорхойлох зэрэг ажлууд хийгдсэн. Энэ хууль нь авлигын талаарх ойлголтыг өгсөн бөгөөд түүний төрлүүдийн талаар илүү нарийн ойлголтыг авахын тулд дараах хуулиудтай танилцах хэрэгцээ гарсан.

**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль** - Энэ хуулиас мөн авлигын төрлүүдийн талаарх илүү нарийвчилсан ойлгуултуудыг авч, тэдгээрийн үйлчлэх хүрээг тогтоосон. Энэ хуулинд үндэслэн судалгааны гол асуудлыг сонгож, “бэлэг” гэх авлигын хэлбэрийг судлахаар тодорхойлсон юм.

**Эрүүгийн хууль** - Эрүүгийн хуульд авлигын хамгийн хүнд хэлбэр болох хээл хахууль авсан болон өгсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх бөгөөд энэ хуулийн 28-р бүлэг “Албан тушаалын гэмт хэрэг” гэх бүлэгт илүү хамааралтай юм. Энэ бүлгийн 270-р зүйлд их хэмжээний эд хөрөнгө, мөнгө авсан тохиолдолд хорих ялаар юуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хэд дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний торгууль ноогдуулдаг байна. Гэхдээ бидний судалгаанд гол асуудал нь авлигын “бэлэг” хэмээх ойлголтыг авч салбарын хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм, журмын дагуу захиргааны арга хэмжээ авах хэмжээний ойлголтыг түлхүү оруулав.

**Авлигын эсрэг хууль тогтоомжийг таниулах нь: Нийтийн албан тушаалтны гарын авлага** - Дээрх хоёр хуулийн хүрээнд нийтийн албан тушаалтнуудад зориулан гаргасан гарын авлагатай танилцаж судлаачдын сургалтад ашигласан.

**Нийтийн албан тушаалтан танд хуулиар юуг зөвшөөрч, юуг хориглох вэ?: АТГ-аас гаргасан гарын авлага** - Мөн үүнийг судлаачдын сургалтад ашигласан.

**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль: 100 асуулт, хариулт** - Мөн үүнийг судлаачдын сургалтад ашигласан.

**Эмнэлгийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын схем, жагсаалт** - Судалгааны түүвэрлэлтийг сонгох, үйлчилгээг жигд хамруулахын тулд сонгосон эмнэлэг тус бүрийн үйлчилгээний төрөл, зохион байгуулалтыг судлав.

**Эрүүл мэндийн үзүүлэлт 2012** - Судалгааны эрүүл мэндийн үйлчилгээ, түүвэр зэрэгтэй холбоотой зарим үр дүнг энэхүү эрүүл мэндийн салбарын статистик үзүүлэлттэй харьцуулсан.


**Статистикийн эмхэтгэл, 2012** - Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл, орлогын байдал зэргийг тооцохдоо статистикийн ангиллыг ашиглан хэрэглэгдэхүүн боловсруулсан.

**Хүн амын үзүүлэлтүүдийн өөрчлөлт, өнөөгийн байдал, 2013**  
Судалгааны хүн ам зүйн хэсгийн үр дүнг харьцуулахад ашигласан.

## 2. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү бүлэгт нийт судалгаанд оролцогчдын хүн ам зүйн мэдээлэл болоод судалгааны ажилтай холбогдолтой ерөнхий мэдээллүүдийг хүргэх болно. Эрүүл мэндийн салбарын авлигын нөхцөл байдлын талаарх судалгааны ажил нь Улаанбаатар хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 1,2,3-р шатлалын эмнэлгүүдээс түүвэрлэн нийтдээ 700 үйлчлүүлэгч, 111 эмч, 90 сувилагч судалгаанд оролцсон.

Дүрс 1. Судалгаанд оролцогчдын нас





Судалгаанд оролцогчдын насны бүтцийг ангилахдаа Үндэсний статистикийн хорооны ангиллыг ашигласан. Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчид насны бүлгийн хувьд ерөнхийдөө нийт хүн амын насны бүтцийг төлөөлж чадахуйц болсныг Дүрс 1-ээс харж болохоор байна.

Эмч, сувилагчийн насны бүтэц хөдөлмөрийн насны ажилтнуудыг төлөөлж чадахуйцаар хамруулсан байна.




Дүрс 2. Судалгаанд оролцогчдын хүйс



Монгол Улсын хэмжээнд хүн амын 48,7 хувийг эрэгтэйчүүд, 51,3 хувийг эзэлдэг. Харин судалгаанд хамрагдсан нийт үйлчлүүлэгчдийн дийлэнх нь эмэгтэйчүүд байв. Энэ нь эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлж байгаа хүмүүсийн ихэнхи нь эмэгтэйчүүд байдагтай, мөн судалгаанд Эх нялхасын эрүүл мэндийн төв, амаржих газрууд орсонтой холбоотой (Энэ судалгаа түүврийн хувьд хүйсийн харьцааг чухалчлан үзээгүй).

Эмч, сувилагчийн судалгаанд хамрагдагсдын 45 хувийг сувилагчид эзэлж байгаа нь эмэгтэйчүүд олноор сонгогдоход нөлөөлсөн. Харин эрэгтэйчүүд 14 хувь байгаа нь бүгд эмч нар байв.

Дүрс 3. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин




Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл бүрэн дунд боловсролтой үйлчлүүлэгчид хамгийн өндөр 44,3 хувийг, үүний дараа дээд боловсролтой үйлчлүүлэгчид 38,8 хувь, үүнээс 5,5 хувь нь магистр болон түүнээс дээш зэрэгтэй байна.

Эмч, сувилагчдын 75 хувийг бакалавр зэрэгтэй, 17,5 хувийг магистр болон түүнээс дээш зэрэгтэй эмч, сувилагчид бүрдүүлжээ.

## 2.1 Үйлчлүүлэгчдийн ажил эрхлэлтийн байдал

Энэ хэсэгт судалгаанд оролцсон нийт үйлчлүүлэгчдийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзсэн. Үүний тулд үйлчлүүлэгчдийг ажил эрхэлдэг, ажил эрхэлдэггүй гэсэн хоёр ангилалд авч үзсэн.


Дүрс 4. Үйлчлүүлэгчийн ажил эрхлэлтийн байдал



Үйлчлүүлэгчдийн 58,3 хувийг ажил эрхэлдэг үйлчлүүлэгч эзэлж байгаа бол үлдсэн 41,7 хувийг ажил эрхэлдэггүй үйлчлүүлэгчид эзэлж байна.

Ажил эрхлэлтийн байдлыг статистикийн хорооны ангиллын дагуу задлан харуулбал дараах байдалтай байна.

Дүрс 5. Үйлчлүүлэгчийн ажил эрхлэлтийн ангилал




Ажил эрхэлдэггүй үйлчлүүлэгчийн ажил эрхэлдэггүй шалтгааныг тодруулбал, гэрийн ажилтай иргэд хамгийн их буюу 15,3 хувьтай байна. Үүнд, хүүхдээ хардаг, гэртээ суудаг хүмүүсийг хамруулсан. Үүний дараа 13,2 хувиар тэтгэврийн өндөр настан хамрагджээ.

Нийт судалгаанд оролцсон үйлчлүүлэгчийн 6,7 хувийг суралцагч буюу оюутан, сурагчид эзэлж байна. Харин 4,9 хувь нь хөдөлмөр эрхлэх чадваргүй буюу хөгжлийн бэрхшээлтэй, группэд байдаг хүмүүс байна. Ажил эрхэлдэг үйлчлүүлэгчдийн 34 хувийг цалин хөлстэй ажиллагч эзэлж байгаа ба үүнээс 15,1 хувийг төрийн байгууллагын цалин хөлстэй ажиллагч, 18,9 хувийг хувийн хэвшлийн цалин хөлстэй ажиллагсад эзэлж байна. Үүний дараа хувиараа хөдөлмөр эрхлэгч 19,5 хувьтай хамрагджээ.

Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч 3,9 хувьтай хамрагдсан бөгөөд эдгээрт өрхийн мал аж ахуй, газар тариаланд оролцогч малчин, тариаланч, өөрсдөө худалдаа үйлчилгээ эрхлэгч зэрэг хүмүүсийг энэ бүлэгт хамруулсан.

## 2.2 Эмч, сувилагчдын ажил эрхлэлтийн байдал


Дүрс 6. Эмч, сувилагчийн мэргэшсэн мэргэжил



Судалгаанд оролцсон эмч нарын 45 хувь нь төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нар байгаа нь 2 болон 3-р шатлалын эмнэлэг түлхүү хамрагдсантай холбоотой.

Харин сувилагч нарын хувьд ерөнхий мэргэжлийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн сувилагч нар ойролцоо тоотойгоор хамрагдсан.

### Дүрс 7. Эмч, сувилагчийн мэргэжлийн зэрэг, ажилласан жил



Судалгаанд оролцсон эмч, сувилагчийг мэргэжлийн зэргээр нь ангилан харуулбал зэрэггүй нь дийлэнх буюу 65 хувьтай. Үлдсэн хувь нь ямар нэгэн зэрэгтэй эмч болон сувилагчид байна.

Судалгаанд оролцсон эмч, сувилагчдыг ажилласан жилээр нь ангилан харвал 10-аас дээш жил ажилласан эмч, сувилагчид дийлэнх байгаа бөгөөд 1-3 жил ажилласан эмч, сувилагчид 17 хувийг эзэлж байна.

### Дүрс 8. Ажил үүргээ гүйцэтгэх явцад тулгарч буй хамгийн бэрхшээлтэй асуудал




Судалгаанд оролцсон нийт эмч, сувилагчдаас ажил үүргээ гүйцэтгэх явцад

тулгамдаж буй хамгийн бэрхшээлтэй асуудлын талаар тодруулахад, ажлын ачаалал, иргэдийн эрүүл мэндийн боловсролгүй байдал, иргэдийн бүдүүлэг харилцаа, ажиллах орчин, багаж тоног төхөөрөмжийн дутагдалтай байдал, бага цалинг дурджээ. Тухайлбал, эмч нарын 36,3 хувь нь, сувилагчийн 46,6 хувь нь ажлын ачаалал хэт их байна гэж хариулсан. Ажлын ачаалалтай холбож иргэдийн харилцааны доголдолтой байдлыг нэрлэж байв. Дараалал их, удаан хугацаагаар хүлээлгэх зэргээс шалтгаалж иргэд эмч, сувилагчтай бүдүүлэг харьцдаг нь тэдний ажил үүргээ гүйцэтгэх явцад тулгардаг нэг бэрхшээл гэж хариулжээ.


Харин ажил үүргээ гүйцэтгэх явцад ямар нэгэн бэрхшээл гардаггүй гэж эмч нарын 30,9 хувь нь, сувилагч нарын 17,8 хувь нь үзжээ. Эмч нарыг бодвол сувилагч нарт ажил үүргээ гүйцэтгэх явцад ямар нэгэн бэрхшээлтэй асуудал илүү их байдаг нь харагдаж байна.

*Дүрс 9. Та өдөрт дунджаар хэдэн хүнд үйлчилдэг вэ?*



Өдөрт дунджаар үйлчилгээ үзүүлдэг үйлчлүүлэгчдийн тоо эмч, сувилагчийн ажлын байраас шалтгаалан харилцан адилгүй байлаа. Амбулаторид ажилладаг эмч, сувилагч 20 минут тутамд 1 өвчтөн үзэх ёстой байдаг ба өдөрт дунджаар 20-24 өвчтөн үзэх нормтой байдаг байна. Судалгаанд оролцсон эмч нарын 36,2 хувь, сувилагчдын 48,8 хувь нь өдөрт 30-аас дээш хүнд үйлчилгээ үзүүлж байна.

*Дүрс 10. Та өдөрт дунджаар хэдэн цаг ажилладаг вэ?*




Эмч, сувилагчдын дийлэнх нь хөдөлмөрийн тухай хуульд заасан ажлын 8 цагаар ажилладаг. Эмч, сувилагчдыг харьцуулбал, эмч нар сувилагчдыг бодвол илүү цагаар их ажилладаг ажээ.

Тухайлбал эмч нарын 51,8 хувь нь 8 цаг 31 хувь нь 9 ба түүнээс дээш цаг ажилладаг гэсэн бол сувилагч нарын 66,7 хувь нь 8 цаг ажилладаг байхад 16,7 хувь нь 9 ба түүнээс дээш цаг ажилладаг гэж хариулсан байна.

### 2.3 Судалгаанд оролцогчдын орлогын байдал

Дүрс 11. Судалгаанд оролцогчдын сарын орлого (мянган төгрөг)<sup>2</sup>




Үйлчлүүлэгчдийн орлогыг эмч ба сувилагч нарын сарын орлоготой харьцуулбал үйлчлүүлэгчийн орлого харьцангуй бага байна. Үүнд судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдийн 41,7 нь ажил эрхэлдэггүй болон тэтгэвэр тэтгэмжид хамрагддаг иргэд байсан нь нөлөөлсөн. Өөрийн орлого

<sup>2</sup> Эмч, сувилагчдын сарын орлогыг асуухдаа зөвхөн гар дээр бэлэн олгогдох сарын цалингийн хэмжээг нь тодорхойлуулсан болно.


нь сарын 500 мянган төгрөгөөс дээш орлоготой үйлчлүүлэгчид нийт 26,2 хувийг эзэлжээ. Үйлчлүүлэгчдийн өөрийн сарын дундаж орлого 415396 төгрөг байна.

Дүрс 12. Судалгаанд оролцогчдын өрхийн дундаж орлого (мянган төгрөг)



Судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж орлогыг харьцуулан үзвэл, үйлчлүүлэгчдийн 77 хувь буюу дийлэнх нь 1 сая хүртэлх төгрөгийн өрхийн орлоготой, эмч, сувилагчдын 80,5 хувь нь 500000-1500000 төгрөгийн өрхийн орлоготой байна. Үйлчлүүлэгчдийн хувьд өрхийн дундаж орлого нь 913680 төгрөг байгаа бол эмч, сувилагчдын өрхийн сарын дундаж орлого 1062745 төгрөг байна. 2013 оны статистикаар нийслэлийн өрхийн дундаж орлого 1057430 төгрөг байгаа нь судалгаанд оролцогчдын өрхийн орлогын хэмжээтэй ойролцоо үр дүнтэй байгааг харууллаа.

Дүрс 13. Өрхийн орлогын хүрэлцээ



Судалгаанд оролцогчдоос өрхийн орлого нь амьдралд нь хүрэлцдэг эсэхийг асуухад өдөр тутмын хэрэгцээндээ л хүрдэг гэх хариултыг үйлчлүүлэгч болон эмч, сувилагчдын олонх нь өгч байна.

## 2.4 Үйлчлүүлэгчийн авсан үйлчилгээний талаарх мэдээлэл

Дүрс 14. Үйлчлүүлэгчдийн харьяалал




Дүрс 15 Үйлчилгээ авсан хэлбэр



Нийт судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийг харьяаллаар нь ангилан харвал 79,3 хувь нь Улаанбаатар хотоос үлдсэн 21,7 хувь нь орон нутгаас ирж үйлчилгээ авч байна. Судалгаанд 3-р шатлалын эмнэлгүүд хамрагдсан нь орон нутгаас ирж үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгч олон хамрагдахад нөлөөлжээ.

Судалгаанд үйлчлүүлэгчдийг хамруулахдаа амбулаторын тусламж үйлчилгээ болон хэвтэн эмчлүүлэх хоёр төрлийн үйлчилгээг хамруулсан. Тиймээс оношлогоо, шинжилгээ зэрэг эмнэлгийн бусад үйлчилгээг хамруулаагүй. Мөн энэ хоёр төрлийн үйлчилгээг сонгон түүвэрлэхдээ ойролцоо харьцаатай байхаар сонгосон.

Дүрс 16. Үйлчлүүлсэн кабинет





Судалгаанд оролцогчдыг сонгохдоо бүх төрлийн үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгчдийг хамруулахыг зорьсон


Дүрс 17. Үйлчлүүлсэн тасаг




### 3. АЖИГЛАЛТ

Энэ бүлэгт эрүүл мэндийн салбарын авлигын талаарх дүр зургийг гаргахыг зорив. Судалгаанд оролцогчдын ажиглалтаар эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгөх явдал аль шатлалын эмнэлэгт их ажиглагддаг талаар дэлгэрүүлэн авч судалсан.

*Дүрс 18. Эмч, сувилагчийг үдийн хоол болон оройн хоолоор дайлах тохиолдол аль шатлалд илүү байдаг вэ?*



*Дүрс 19. Эмч, сувилагчид гар цайлгах багахан эд зүйл өгөх тохиолдол аль шатлалд их байдаг вэ?*




Үйлчлүүлэгчийн 53 хувь нь, эмч сувилагчийн 49,5 хувь нь 3-р шатлалын эмнэлэгт эмч, сувилагчийг хоолоор дайлах явдал байдаг гэж үзжээ. Энэ талаар сайн мэдэхгүй байна гэж эмч, сувилагчдын 36 хувь, үйлчлүүлэгчийн 21,7 хувь нь үзсэн байна. Харин 1-р болон 2-р шатлалын эмнэлгийн хувьд хоолоор дайлах тохиолдол бага байгааг судалгааны үр дүнгээс харж болно.

Үйлчлүүлэгчдийн 88,7 хувь нь, эмч сувилагчдын 78,5 хувь нь 1,2,3-р шатлалын эмнэлгүүдэд бяцхан гар цайлгах явдал ажиглагддаг гэж үзсэн байна. Бяцхан гар цайлгаж, эд зүйл өгөх тохиолдол нь үдийн болон оройн хоол авч өгөхөөс ялгаагүй. Эмч, сувилагчийн хариулж буйгаар бяцхан гар цайлгах явдал нь бүх шатлалын эмнэлгүүдэд байдаг хэдий ч 3-р шатлалын эмнэлэгт илүүтэй ажиглагддаг ажээ.

Миний хүү Б-г зүрхний мэс заслын хагалгаанд орж байхад хагалгаа хийсэн багт захиалгын хоол авч өгч байсан. Ер нь бол хагалгаанд орсон хүүгээ хүлээгээд сууж байхад иргэд дандаа л захиалгын хоол эмч нарт өгч байгаа нь харагддаг. Би ч тэд нартай адилхан хоол захиалж өгөх хэрэгтэй юм байна гэж бодсон доо.


Иргэн П-ийн ярилцлагаас, УГТЭ

Дүрс 20. Эмч, сувилагчид бэлэн мөнгө өгөх тохиолдол аль шатлалд илүү байдаг вэ?



Дүрс 20-оос харахад үйлчлүүлэгчдийн 86,9 хувь нь, эмч сувилагчдын 67 хувь нь бэлэн мөнгө өгөх явдал ажиглагддаг хэмээн хариулсан байна. 1,2,3-р шатлалын эмнэлгүүдэд бэлэн мөнгө өгөх явдал их, бага хэмжээгээр ажиглагддаг хэдий ч 3-р шатлалын эмнэлгүүдэд бэлэн мөнгө өгөх явдал хамгийн их ажиглагддаг ажээ.

Дүрс 21. Таны ажигласнаар хамгийн нийтлэг хэлбэр нь юу байна вэ? (олон сонголттой асуулт)



Үйлчлүүлэгчдийн ажигласнаар 55,6 хувь нь бэлэн мөнгө эмч, сувилагчид өгөх тохиолдол ажиглагддаг гэсэн бол эмч сувилагчдын ажигласнаар 55,2 хувь нь набор, вино, шоколад өгч байгаа нь ажиглагддаг хэмээн хариулсан байна.

Харин эмч сувилагчдын 20,3 хувь нь бэлэн мөнгө өгөх явдал ажиглагддаг гэсэн бол үйлчлүүлэгчийн 29,2 хувь нь набор, вино, шоколад өгөх явдал ажиглагдсан гэж хариулсан байна.


*Хүний амь настай холбоотой хүнд мэс ажилбар, эсвэл хүүхэд төрүүлэхэд дандаа л дугтуйтай мөнгө өгдөг болчихсон ш дээ. За яахав зүгээр хэвтэж эмчилгээ хийлгүүлэхэд набор, вино гэх зэрэг зүйлийг иргэд өгч байгаа нь харагддаг. Хүмүүс эмч нарыг тасгаар орж гарах болгонд гарт нь юм бариулж гаргадаг.*

*Иргэн С-ийн ярилцлагаас ЭХЭМҮТ*

## 4. ОЙЛГОЛТ БА ХАНДЛАГА

Энэ бүлэгт судалгаанд оролцогчдын эрүүл мэндийн салбарын авлигын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлохыг зорилоо. Судалгаанд оролцогчид бэлэг сэлт, мөнгө өгөх явдлыг хэрхэн хүлээж авч байгаа болоод ирээдүйд бэлэг сэлт, мөнгийг жишиг болгон эмч, сувилагчид өгөхийг зөвшөөрч байгаа эсэхийг энд тодруулсан.

Дүрс 22. Эмч, сувилагчид бэлэг өгөх нь байж болох зүйл




Эмч, сувилагчид баярлаж талархсан сэтгэлээ илэрхийлж бэлэг өгөх нь байж болох зүйл гэж нийт судалгаанд оролцогчдын 66,5 хувь нь хариулсан байна. Үүнийг үйлчлүүлэгч, эмч сувилагчаар харьцуулахад төдийлөн ялгаа гараагүй. Үүнээс үзэхэд, үйлчлүүлэгч талархсан сэтгэлээ илэрхийлж байгаа тохиолдолд бэлэг өгөх явдлыг олон нийт хүлээн зөвшөөрч байна.

Эмч, сувилагчид бэлэг сэлт, эсвэл жижиг хэмжээний эд зүйл өгөхийг зөвшөөрөх хэрэгтэй. Монголчууд бид чинь баярласан сэтгэлээ өөрөөр илэрхийлж мэдэхгүй хүмүүс. Набор, вино өгөхдөө нууж өгөөд л, эмч нь нууж аваад л. Энэ байдлыг ил болгох хэрэгтэй. Бэлэг өгөхийг хүлээн зөвшөөрчихвөл иргэд бэлэн мөнгө өгөхөө больчихно ш дээ.


Иргэн Б-ийн ярилцлагаас БГД-ийн ЭМН

Дүрс 23. Эмч, сувилагчид мөнгө өгөх нь байж болох зүйл




Судалгаанд оролцогчийн 83,5 хувь нь эмч, сувилагчид бэлэн мөнгө өгөх нь байж болохгүй зүйл гэж үзсэн бол 16,5 хувь нь байж болох зүйл хэмээн үзжээ. Эмч, сувилагчид бэлэг сэлт өгөх явдалд бүх хүн эергээр хандаж байгаа ч бэлэн мөнгө өгөх явдалд сөрөг хандлагатай нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

*Дүрс 24. Үйлчлүүлэгчид чанартай үйлчилгээ авахын тулд өөрсдөө бэлэг өгдөг*




Дээрх дүрсээс харахад үйлчлүүлэгч болоод эмч, сувилагчийн хариулт ялгаатай байгааг харж болохоор байна. Үйлчлүүлэгчдийн 80 хувь нь чанартай үйлчилгээ авахын тулд бэлэг сэлт, мөнгө өгдөг гэсэн ойлголттой байхад эмч, сувилагчдын 59 хувь нь бэлэг сэлт мөнгө өгөх нь үйлчилгээний чанарт нөлөөлөхгүй гэж хариулсан байна.

*Дүрс 25. Эмч, сувилагчдын цалин бага байгаа нь бэлэг авах шалтгаан болдог*



Үүнийг эмч, сувилагчид болон үйлчлүүлэгчээр харьцуулан харвал цалинтай холбоотой гэсэн хариулт 13 хувиар ялгаатай байна. Энэ нь үйлчлүүлэгчид эмч, сувилагчийн цалин бага байгаа нь тэднийг бэлэг авах шалтгаан болдог гэж ойлгож байгаа бол эмч, сувилагч нар өөрсдөө үүнийг голлох шалтгаан гэж үзэхгүй байна. Судалгаанд оролцогчдын 50,5 хувь нь эмч, сувилагчийн цалин бага байгаа нь бэлэг, мөнгө авах шалтгаан болдог гэж үзсэн бол 49,5 хувь нь үүнтэй холбоогүй гэж үзжээ.

*Дүрс 26. Өгснийг нь их бага хэмжээгээр аваад байх нь цаашид авах сонирхол төрүүлж болзошгүй*




Эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө аваад байх нь цаашид авах сонирхол төрүүлж болзошгүй гэж үйлчлүүлэгчдийн 88 хувь үзэж байхад, эмч, сувилагчдын 58 хувь нь ингэж хариулжээ. Үүнээс үзэхэд үйлчлүүлэгчийн ойлголтоор эмч, сувилагч нь их бага хэмжээгээр бэлэг сэлт авах нь цаашид авах сонирхолтой болдог гэж болгоомжилсон байна.

Мэс засалд орсны дараа хэвтэж байхад эмч, сувилагч нарт бэлэг өгсөн өвчтөнд илүү ханддаг. Тэр нь байн байн орж ирж биеийг асуугаад эргэлтээр ирсэн хүмүүсийг нь тасагт хамаагүй оруулдаг. Бас өвчин намдаагч өгөх зэргээр хандлага нь шал өөр болчихдог.


Иргэн Б-ийн ярилцлагаас БГД ЭМН

Дүрс 27. Үйлчлүүлэгчээс өгсөн мөнгө, бэлэг сэлт үйлчилгээний чанарт нөлөөлдөг




Эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгөх нь үйлчилгээний чанарт нөлөөлдөг гэж үйлчлүүлэгчдийн олонхи үзсэн. Харин эмч, сувилагчдын дийлэнх нь бэлэг сэлт, мөнгө өгөх нь үйлчилгээний чанарт нөлөөлөхгүй гэж хариулжээ. Энэ асуудалд эмч, сувилагч ба үйлчлүүлэгчдийн ойлголт зөрүүтэй байна.

Дүрс 28. Мөнгө, шан харамж авах нь ёс суртахуун, хүн чанар муудсаны илрэл




Эмч, сувилагчдын үзэж байгаагаар 59 хувь нь мөнгө шан харамж авах нь ёс суртахуун муудсаны илрэл биш гэсэн байхад үйлчлүүлэгчдийн 64 хувь нь мөнгө шан харамж авах явдал нь ёс суртахуун муудсаны илрэл гэж хариулжээ. Эмч, сувилагчдын хувьд үйлчлүүлэгчийн баярласан сэтгэлийг хүлээж авч байгаа учир энэ нь ёс суртахуунгүй үйлдэл биш гэж тайлбарлаж байв.

Дүрс 29. Эрүүл мэндийн салбарт эмч, эмнэлгийн ажилтнуудад бэлэг сэлт, мөнгө өгөх, танил талаараа давуу үйлчлэх нь зөв үү?



Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдийн хувьд эмч, эмнэлгийн ажилтан нь бэлэг сэлт, мөнгө авах нь буруу гэсэн байр суурьтай байдгийг судалгааны үр дүнгээс харж болно.

Дүрс 30. Эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгөх явдал цаашид жишиг болохыг та зөвшөөрөх үү?



Судалгаанд оролцогчдын 93,5 хувь нь эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгөх явдлыг цаашид жишиг болохыг зөвшөөрөхгүй гэж үзсэн.




## 5. ХУВИЙН ТУРШЛАГА

Энэ бүлэгт манай судалгаанд оролцогчдоос өөрийн биеэр бэлэг сэлт, мөнгө өгсөн, бэлэг сэлт, мөнгө авсан гэж хариулсан хүмүүсийн үр дүнг харуулна. Тиймээс бэлэг сэлт, мөнгө өгч байгаагүй үйлчлүүлэгч болон бэлэг сэлт, мөнгө авч байгаагүй эмч, сувилагчдыг энд хамруулаагүй.

### 5.1 Үйлчлүүлэгчийн хувийн туршлага


Судалгаанд хамрагдсан нийт 700 үйлчлүүлэгчээс 385 хүний хувийн туршлага мэдээллийг энэ дэд бүлэгт дурдах юм.

*Дүрс 31. Сүүлийн нэг жилийн хугацаанд та болон таны ойр дотныхон үйлчилгээ авахтай холбогдуулж эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгөх тохиолдол гарсан уу?*



Судалгаанд оролцсон нийт 700 үйлчлүүлэгчдийн 385 буюу 55 хувь сүүлийн нэг жилийн хугацаанд эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгсөн тохиолдол гарчээ. Үүнээс 23 хувь нь өөрөө өгсөн бол, 32 хувь нь ар гэрийнхэн нь өгсөн гэж хариулжээ.


*Дүрс 32. Хэрэв тийм бол аль эмнэлэгт бэлэг өгсөн бэ?*



Эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгсөн нийт тохиолдлыг эмнэлэг тус бүрээр нь харьцуулан харвал хамгийн өндөр хувьтай нь УНТЭ болон ЭХЭМҮТ байна. Үүний дараа 3-р төв эмнэлэг болон ГССҮТ-ийг нэрлэгджээ.

Харин хамгийн бага бэлэг өгсөн тохиолдлууд нь өрхийн ЭМТ, аймгийн нэгдсэн эмнэлэг болон УХТЭ байна. Бусад гэсэн хариултад Төмөр замын эмнэлэг, хүүхдийн клиник зэрэг эмнэлгүүд багтсан болно. Дүүргийн ЭМН болон аймгийн нэгдсэн эмнэлгүүдийн дундаж утгыг бодож гаргасан. Дүүргийн ЭМН-д БГД, СХД, БЗД, ХУД-үүдийг нэрлэсэн бол аймгийн нэгдсэн эмнэлэгт Хөвсгөл, Хэнтий, Ховд, Дорнод, Завхан, Төв аймгуудыг нэрлэжээ.

Дүрс 33. Тухайн зүйлээ хэнд өгсөн бэ? (Олон сонголттой асуулт)




Тухайн бэлэг сэлт, мөнгийг хэнд өгч байгаа субъектээр нь авч үзвэл 70,6 хувийг эмчид, 27,2 хувийг сувилагчид өгсөн бол 2,2 хувийг л эмнэлгийн бусад ажилтнуудад өгчээ. (Эмч, сувилагч, асрагчид ямар зүйл өгснийг дүрс 58-аас харна уу)

*Ээжийгээ түргэн хагалгаанд оруулахын тулд хариуцсан эмчтэй нь уулзаж хоолонд оруулж мөнгө өгсөн. Хагалгаанд орсных нь дараа хагалгаанд орсон багийг хоолонд оруулж, бас чихэр жимс набор мөнгө өгсөн. Хамгийн их юмыг эмчид нь л өгсөн дөө.*


*Иргэн Б-ийн ярилцлагаас ХСҮТ*

Дүрс 34. Ямар төрлийн үйлчилгээ авахтай холбоотойгоор тухайн зүйлийг өгсөн бэ?




Ямар төрлийн үйлчилгээ авахтай холбоотойгоор тухайн зүйлийг өгсөн бэ? гэсэн асуултад мэс засалд орох болон төрөх үйлчилгээнд орохдоо гэсэн хариулт хамгийн өндөр хувьтай байна. Мөн үүний дараа хэвтэн эмчлүүлэхэд бэлэг өгдөг гэх хариулт багагүй хувийг эзэлжээ. (Эдгээр үйлчилгээг авахдаа юу өгдөг талаар дүрс 59-өөс харна уу)

Дүрс 35. Тухайн үйлчилгээг авахдаа хэдэн удаа бэлэг өгөх хэрэгтэй болсон бэ?



Нэг үйлчилгээ авахын тулд бэлгийг гол төлөв 1 удаа л өгдөг байна. Харин олон удаа буюу 4-өөс олон удаа өгөх тохиолдол 1,6 хувьд нь гарчээ.

## Дүрс 36. Таны өгсөн зүйл юу байсан бэ?




Үйлчлүүлэгчдийн эмч, сувилагчид өгч буй бэлгийг төрлөөр авч үзвэл дийлэнх хэсэг нь бэлэн мөнгийг хамгийн ихээр өгчээ. Үүний дараа набор, вино, шоколад зэрэг жижиг бэлгийн төрөл орж байгаа ч бэлэн мөнгө өгч байгаа хэсэгтэй харьцуулахад нэлээд бага байна. (Аль шатлалын эмнэлэгт юу өгч байгааг дүрс 67-оос харна уу)

Эхний элэгний хагалгааны багт 500 мянган төгрөг өгсөн. Угаасаа хагалгаанд орсон эмч нар нь хуваагаад авчихдаг уламжлалтай юм шиг байна билээ. Хагалгаа дууссаны дараа хагалгаа гайгүй боллоо, та эмчтэй нь уулзаарай гэж сувилагч хэлсэн. Мөнгөө өгөхдөө хагалгааны дараа өгсөн л дөө. Харин маргааш нь уушигны хагалгаанд ороход нь бас 500 мянган төгрөг, гэхдээ өмнө нь хагалгаа удирдах эмчид нь өгсөн. Хамгийн сүүлийн хагалгаагаар 200 мянган төгрөг өгсөн. Тэгэхдээ эмнэлэгт байх хугацаанд нь тэр өдөр ээлжинд гарч байгаа сувилагч болгонд л 10000, 20000 төгрөг өгдөг байсан. Өөрөө ч сэрэнгүүтээ мөнгө өг гэж хэлсэн. Аминдаа дотор орж асарч чадахгүй болохоор сайн асраасай л гэж боддог байсан. Өдөрт 2 удаа л дотогшоо ордог болохоор орж гарах бүртээ л мөнгө өгч байсан. Нийтдээ дор хаяж сувилагч нарт нь л 500 мянган төгрөг бол өгсөн. Жишээ нь боолт солиулах бүртээ л тухайн хүнд нь 40000 төгрөг өгч байсан.

Иргэн Т-ийн ярилцлагаас, ГССҮТ

Дүрс 37. Таны эмч, сувилагчид өгсөн зүйл дунджаар ямар өртөгтэй байсан вэ? (мянган төгрөг)<sup>3</sup>



Судалгааны үр дүнгээс харахад эмч болон сувилагчид өгч буй бэлэг сэлт, мөнгөний өртөг ялгаатай байна.

Эмчид өгсөн бэлэг сэлт, мөнгөний өртөг 1000–1800000 төгрөг хүртэлх тохиолдол дурдагдсан бол эмчид өгч буй бэлгийн дундаж өртөг 121905 төгрөг байна.

Сувилагчид өгсөн бэлгийн өртөг 1500 – 300000 төгрөг байсан бөгөөд дундаж өртөг нь 57612 төгрөг байжээ.

Эмч болон сувилагчид өгсөн бэлгийн өртөг хамгийн ихдээ 1800000 төгрөг байсан тохиолдол гарчээ. (Эмч, сувилагчид өгсөн зүйлийн өртөгийн хэмжээг дүрс 64,65-аас харна уу)


<sup>3</sup> Тухайн өгсөн зүйлийг мөнгөн дүнд шилжүүлсэн ойлголт бөгөөд бүлэглэхдээ 25000 төгрөгөөр шаталсан нь эмч, сувилагчдын 1 өдрийн дундаж цалингийн хэмжээтэй ойролцоо байгаа юм.

Хавдрын эмчийг хоолонд оруулах гээд очиж авахдаа ажлынхантайгаа хуваагаад идээрэй гээд архи, набор, чихэр, жүүс гэх мэт ууттай зүйл өгсөн, тэр нь ойролцоогоор 80000-90000 төгрөг болсон. Тэгээд тэр эмчийг гаргаж ирээд хоолонд оруулж байхдаа хагалгаанд оруулаад өгөөч гэж гуйх үедээ тэр эмчид 500000 төгрөг өгсөн. Тэр өдрийн хоолны мөнгө бараг 80000 төгрөг болсон. Бас хагалгааны дараа хагалгаанд орсон 1 нойрсуулагч эмч, 2 сувилагч, эмэгтэйчүүдийн 2 их эмч, хагалгаа удирдаж байсан бие эрхтний мээ заслын ерөнхий эмч гээд ерөнхий удирдамжийг нь хийсэн 1 эмч гэсэн бүрэлдэхүүнтэй байсан. Нойрсуулагч эмч нь чухал үүрэг гүйцэтгэдэг гээд ээж өг гэсэн учраас тэр эмчид нь архи, чихэр гэх мэт зүйл тусад нь авч өгсөн. Бас хагалгаа хийсэн эмч (мөнгө авсан эмч) нь тэр хагалгааны дараа амралтаа авч байгаа гээд тэд нар ууж идэж байхад нь архи, чихэр, жимс авч өгсөн. Тэр анх 500000 төгрөг авсан эмч хэлэхдээ, тэр мөнгөө хагалгааныханд нь хуваасан шүү гэж хэлсэн болохоор нь өөр мөнгө өгөөгүй. Гэхдээ тэр ууж идэх юм авч өгөхөд л бараг 80000-90000 төгрөг болж байсан.

Иргэн Э-ийн ярилцлагаас, ХСҮТ

## 5.2 Эмч, сувилагчийн хувийн туршлага


Дүрс 38. Таныг үйлчилгээ үзүүлэх явцад үйлчүүлэгч болон түүний ар гэрээс ямар нэг зүйл өгөх, эсвэл бусад байдлаар талархлаа илэрхийлсэн тохиолдол сүүлийн нэг жилийн хугацаанд гарсан уу?



Судалгаанд оролцсон эмч, сувилагчийн 132 буюу 66 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд үйлчлүүлэгчээс ямар нэг зүйл авсан гэж хариулжээ.

Ямар нэгэн зүйл гэдэгт мөнгө, бэлэг сэлт зэргийг оруулсан бөгөөд аман болон бичгэн байдлаар илэрхийлсэн сэтгэлийн бэлгийг тооцоогүй. Хэрвээ тухайн жилд ямар нэгэн зүйл авсан тохиолдол олон байгаа бол хамгийн сүүлийн туршлагыг сонгож авсан. Ямар нэгэн зүйл сүүлийн нэг жилийн хугацаанд огт аваагүй эмч, сувилагч нарын тоо 69 буюу 34 хувьтай байна.


Дүрс 39. Үйлчлүүлэгчээс сүүлийн 1 жилийн хугацаанд ямар нэгэн зүйл өгөх тохиолдол гарсан байдал



Сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэгэн зүйл авсан гэж хариулсан 132 эмч, сувилагч нарыг эмнэлэг тус бүрээр нь мөн эмч, сувилагчаар нь ялгаж харуулбал эмч, сувилагчийн хооронд төдийлөн ялгаатай байдал харагдахгүй байна.


Төрөх эмнэлгүүдийн хувьд сувилагч нар нь сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэг зүйл авсан тохиолдол эмч нарынхаас их байна. ЭХЭМҮТ-өөс судалгаанд оролцсон бүх сувилагч нар сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэг зүйл үйлчлүүлэгчээс авсан гэж хариулжээ.

Дүрс 40. Нэг жилийн хугацаанд танд ямар нэг зүйл өгөх тохиолдол хэдэн удаа гарсан бэ?




Сүүлийн нэг жилийн хугацаанд үйлчлүүлэгчээс ямар нэг зүйл авсан гэж хариулсан 132 эмч, сувилагчаас 33,3 хувь нь үйлчлүүлэгчдээс ямар нэг зүйл өгөх тохиолдол сардаа 1-2 удаа тогтмол гардаг гэсэн байна. Харин жилдээ 1-2 удаа өгдөг гэж 30,3 хувь нь хариулжээ. (Эмч, сувилагчийн мэргэшлийг ямар нэгэн зүйл өгсөн давтамжтай харьцуулсаныг дүрс 63-аас харна уу)

Дүрс 41. Хамгийн сүүлд танд юу өгсөн бэ? (Олон сонголттой асуулт)



Эмч, сувилагч нарын 74 хувь нь набор, вино, шоколад гэх мэт жижиг бэлэг, 7 хувь нь бэлэн мөнгө авсан гэж хариулсан, харин сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэгэн зүйл өгсөн гэж хариулсан үйлчлүүлэгчдийн 69,7 хувь нь бэлэн мөнгө өгсөн гэсэн хариулт хэлжээ. Өөрөөр хэлбэл, өгсөн авсан зүйл дээр эмч, сувилагч болон үйлчлүүлэгчдийн хариулт хамгийн их зөрүүтэй байгаа юм. (Аль шатлалын эмнэлэг юу авч байгааг дүрс 68-аас харна уу)


Дүрс 42. Хамгийн сүүлд танд юу өгсөн бэ? (Олон сонголттой)



Ямар нэгэн зүйл үйлчлүүлэгчээс авсан гэж хариулсан эмч, сувилагч нарын хамгийн сүүлд авсан зүйлийг эмч, сувилагчаар нь ялгаж харуулбал эмч болоод сувилагчийн хариултауд төдийлөн ялгаагүй байна. Бэлэг дурсгалын зүйл авах тохиолдол сувилагч нарыг бодвол эмч нарт их байгаа бол өдрийн хоол болон оройн хоолоор дайлуулах тохиолдол сувилагч нарт илүү ажиглагдаж байна.



Дүрс 43. Танд өгсөн зүйл дунджаар ямар өртөгтэй байдаг вэ?



Ямар нэгэн зүйл үйлчлүүлэгчээс авсан гэж хариулсан эмч, сувилагчийн бэлэгний өртгийг эмч, сувилагчаар нь харьцуулбал төдийлөн ялгаа гараагүй, судалгаанд оролцсон эмч, сувилагчийн хариултуудаас өгсөн зүйлийн өртөг хамгийн багадаа 100 төгрөг, хамгийн ихдээ 100000 төгрөг байна.


Гэтэл үйлчлүүлэгчдийн дөнгөж 23,6 хувь нь эмч нарт өгсөн бэлэгний дундаж өртөг 25000 төгрөг хүртэл байсан гэж хариулсан билээ. Өөрөөр хэлбэл, бэлэг өгсөн тал бэлэг авсан тал хоёр бэлэгнийхээ өртгийг эрс зөрүүтэй үнэлж байна. Сувилагчдын хувьд үйлчлүүлэгчээс өгсөн зүйлийн өртгийг 25000 төгрөгөөс доош байдаг гэж 93,4 хувь нь үзсэн бол, үйлчлүүлэгчдийн 44,6 хувь нь сувилагчдад өгсөн бэлэгний дундаж өртөг 25000 төгрөгөөс бага байсан гэж үзжээ.

Өөр нэг сонирхолтой баримт бол 150000 төгрөгөөс дээш өртөгтэй бэлэг өгсөн гэж судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдийн 24,7 хувь нь хариулсан бол эмч нарын хувьд 150000 төгрөгөөс дээш өртөгтэй бэлэг авсан гэж хариулсан тохиолдол гараагүй.

## 6. ШАЛТГААН НӨХЦӨЛ

Энэ бүлэгт үйлчлүүлэгчийн бэлэг сэлт, мөнгө өгч буй шалтгааныг болон эмч, сувилагчдын тухайн бэлэг сэлт, мөнгө авч буй шалтгааныг тодруулсан үр дүнгүүдийг тайлбарласан.

*Дүрс 44. Үйлчилгээний аль шатанд өгсөн бэ? /Олон сонголттой асуулт/*




Үйлчлүүлэгчээс эмч, сувилагчид үйлчилгээний аль шатанд бэлэг сэлт, мөнгө өгснийг тодруулахад үйлчилгээ авахаас өмнөх болон дараах шатуудад ойролцоо өндөр хувьтай хариултуудыг өгчээ. Ялангуяа үйлчилгээ авсны дараа бэлэг сэлт, мөнгө өгсөн гэж нийт бэлэг өгсөн үйлчлүүлэгчийн тал хувь хариулсан. Харин үйлчилгээ авахаас өмнө болон дараа аль аль шатанд, олон давтамжтай бэлэг сэлт, мөнгө өгсөн гэх хариулт 6,7 хувийг эзэлжээ.

Нийт бэлэг сэлт, мөнгө өгсөн үйлчлүүлэгчдээс ямар шалтгаанаар тухайн зүйлээ өгсөн шалтгааныг тодруулахдаа үйлчилгээний өмнөх шатанд болон дараах шатанд гэсэн ялгаатай байдлаар тодруулсан.

(Хэвтэн эмчлүүлэх болон, үзлэг хийлгэхдээ эмч сувилагчид бэлэн мөнгө өгсөн шалтгааныг дүрс 62-оос харна уу)

### Дүрс 45. Үйлчилгээ авахаас өмнө өгөх болсон шалтгаан юу вэ?



Үйлчилгээ авахаас өмнө бэлэг сэлт, мөнгө өгсөн шалтгааны тал орчим хувь нь өөртөө анхаарал илүү хандуулж, сайн үйлчилгээ авах зорилготой байжээ. Ер нь үйлчлүүлэгчид үйлчилгээг илүү сайн, хурдан шуурхай авах үүднээс өөрсдөө санаачилж бэлэг сэлт, мөнгө өгдөг байна.

Манай ээж 2013 оны 7 сард Эх нялхас-д очиж үзүүлээд савны хорт хавдар гэж оношлогдоод тэндээ хагалгаанд орж байсан. Ойролцоогоор эмнэлэгт 10 орчим хоног хүлээж байж хагалгаандаа ороод гарч байсан. Тэгэхдээ тэр үед Эх нялхас дээр банкинд оочерлож байгаа юм шиг арай гэж нэг оочерлож, шинжилгээний 99000 төгрөг тушааж байж хэвтэх оочероо авсан. Тэр үед маш хүнд сурталтай хэцүү байсан. Эмчилгээний мөнгө гэж 350000 төгрөг тушаасан. Бас хажуугаар нь хагалгаа хийсэн эмч нарт нь 140000 төгрөг өгсөн. Гэсэн ч 10 сард дахиад савны хорт хавдар үлдсэн байна, дутуу авсан байна гэдэг шалтгаанаар Хавдар судлал дээр очих болсон. Маш их оочертой одоогоор хагалгаа хийх боломж байхгүй, хүлээлгэнд ор гээд хүлээлгээд байсан. Тэгэхээр нь танилаараа яриулж байгаад хавдар судлалын эмэгтэйчүүдийн их эмчийг нь урьж хоолонд оруулж, гуйж байж тус эмнэлэгт хэвтэж хагалгаанд орсон.

Иргэн Б-ийн ярилцлагаас, ХСҮТ

Дүрс 46. Үйлчилгээ бүрэн авсныхаа дараа өгөх болсон шалтгаан юу вэ?



Үйлчлүүлэгч үйлчилгээ авсныхаа дараа ихэвчлэн баярласан, талархсан сэтгэлээ илэрхийлэх нь бэлэг сэлт, мөнгө өгөх шалтгаан болдог гэсэн хариулт дийлэнх хувийг эзэлж байна. Гэхдээ бусад үйлчлүүлэгчийн бэлэг сэлт, мөнгө өгч буй жишгийг дагах, эсвэл дараа нь үйлчлүүлэхээ бодож бэлэг сэлт, мөнгө өгдөг тохиолдол багагүй хувийг эзэлж байна.

Эмч, сувилагчдад бэлэг сэлт, мөнгө өгөх санаачлага үйлчлүүлэгчдээс ихэвчлэн гарч байгаа ч эмч, сувилагчид өөрсдөө бэлэг сэлт, мөнгө авахыг хүссэн тохиолдол 14 хувьтай байна.

*Хамт эмчлүүлж байсан бүх хүмүүс л өгдөг гэж ярьж байсан. Бусдын жишгээр л мөнгө өгчихсөн. Тэрнээс биш баярласандаа өгөөгүй. Эмчдээ мөнгө өгсөн чинь шууд аваад л явчихдаг юм байна лээ.*

*Иргэн С-ийн ярилцлагаас ЭХЭМҮТ*

Дүрс 47. Эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгсний дараа юу өөрчлөгдсөн бэ?




Бэлэг сэлт, мөнгө өгсний дараа юу өөрчлөгдсөн тухай үйлчлүүлэгчдээс тодруулахад ямар нэгэн хэмжээнд үйлчилгээ сайжирсан үзүүлэлт 78,5 хувьтай байна. Хэдийгээр бэлэг сэлт, мөнгө өгсөн ч хүссэн хэмжээнд өөрчлөлт гараагүй гэж 13,3 хувь нь хариулсан.

*Хагалгаанд шууд 2 хоногийн дараа орсон. Бид нар бас чөлөөтэй тасагруу нь орж гардаг болсон. Өмнө нь бол нэг удаа л ор, халаад өмс гэх мэт их уурладаг байсан бол дараа нь чөлөөтэй, олуулаа ч хамаагүй орж гардаг болсон. Үйлчилгээ нь ч гэсэн сайжирсан. Эмч нь хүртэл байн байн орж гараад, биеийг нь сураглаж асуугаад, сувилагчаараа биш өөрөө 2, 3 удаа өвчин намдаах тариа хийх гэх мэт их өөрчлөгдсөн.*


Иргэн Б-ийн ярилцлагаас ХСҮТ

Дүрс 48. Үйлчлүүлэгч ямар шалтгаанаар танд бэлэг өгсөн гэж бодож байна вэ?



Сүүлийн нэг жилийн хугацаанд үйлчлүүлэгчээс ямар нэгэн зүйл авсан гэж хариулсан эмч, сувилагч нараас тухайн зүйлийг ямар шалтгаанаар өгсөн гэж бодож байгаа талаарх асуултад нийт эмч, сувилагч нарын 78 хувь нь үйлчлүүлэгч, түүний ар гэр баярлаж талархаад өгсөн гэж боддог гэсэн бол үйлчилгээг бүрэн авч дуусаад эмч, сувилагчид ямар нэгэн зүйл өгсөн үйлчлүүлэгчдийн 66 хувь нь мөн эмчилгээ, үйлчилгээ сайн байсан учраас баярлаад өгсөн гэж хариулжээ. Харин үйлчилгээ авахаасаа өмнө бэлэг сэлт, мөнгө өгсөн үйлчлүүлэгчдийн 45,7 хувь нь эмч, сувилагч нарын анхаарлыг хандуулж илүү сайн үйлчилгээ авахын тулд өгсөн гэж хариулсан байна.

Дүрс 49. Та яагаад үйлчлүүлэгчээс өгсөн зүйлийг авсан бэ?



Үйлчлүүлэгчээс сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэг зүйл авсан гэж хариулсан 132 эмч, сувилагч нар үйлчлүүлэгчдийн өгсөн бэлэг сэлт, мөнгө авсан шалтгааны дийлэнх буюу 92 хувь нь тухайн үйлчлүүлэгчийн сэтгэлийг гомдоохгүйн тулд авчээ.

Дүрс 50. Энэ байдлыг өөрчлөхийн тулд та юу хийх хэрэгтэй гэж бодож байна вэ?



Нийт судалгаанд оролцогчид эрүүл мэндийн салбарт тохиолддог бэлэг өгөх болон авах явдлыг өөрчлөхийн тулд дараах ажлуудыг хийх шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд:


1. Цалин нэмэх
2. Иргэдийн бэлэг өгдөг гэсэн ухамсрыг өөрчлөх
3. Эмч, сувилагчийн бэлэг авдаг гэсэн ухамсрыг өөрчлөх
4. Хяналтын системтэй болох гэх зэрэг саналуудыг дурьдсан байна.

Иргэд болон эмч, сувилагчийн ухамсрыг өөрчлөх гэдэгт эдгээр хүмүүсийн дунд сургалт зохион байгуулж эрүүл мэндийн боловсрол олгохоос гадна нийтэд тогтсон жишгийг өөрчлөхийг онцолж байлаа.

## 7. САНХҮҮГИЙН НӨЛӨӨЛӨЛ

Энэ бүлэгт үйлчлүүлэгчийн эмч, сувилагчид өгч буй бэлэг сэлт мөнгө нь тэдний амьдралд хэр нөлөөлж байгааг болон тухайн бэлэг сэлт, мөнгийг авснаар эмч, сувилагчдын амьдралд хэрхэн нөлөөлж байгаа талаар тодруулсан үр дүнг багтаасан.

*Дүрс 51. Та үйлчилгээ авах үедээ эмнэлгийн байгууллагын санхүүд хэдэн төгрөг тушаасан бэ?*



Эдгээр үйлчлүүлэгчийн ихэнх нь 50000 хүртэлх төгрөг төлж үйлчилгээ авсан бол 300,000 төгрөгөөс дээш төлбөр төлсөн нь 23,3 хувьтай байна. 300,001 төгрөгөөс дээш төлбөр төлсөн тохиолдлыг нарийвчлан авч үзвэл:

- ✓ 300,001-1,000,000 хүртэлх төгрөг тушаасан 36 тохиолдол
- ✓ 1,000,001-3,000,000 хүртэлх төгрөг тушаасан 12 тохиолдол
- ✓ 3,000,001-5,000,000 хүртэлх төгрөг тушаасан 4 тохиолдол
- ✓ 5,000,001-7,000,000 хүртэл төгрөг тушаасан 3 тохиолдол байна.



Дүрс 52. Эмчилгээ үйлчилгээ авахтай холбоотой гарсан зардал үйлчлүүлэгчийн гэр бүлийн санхүүд хэр их нөлөөлсөн бэ?




Үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа гаргасан нийт зардал нь тухайн үйлчлүүлэгчийн өрхийн санхүүд бага зэрэг нөлөөлсөн болон нөлөөлөөгүй хариулт нийт 68 хувийг эзэлж байгаа бол үлдсэн 32 хувь нь буюу 3 хүн тутмын 1 нь өрхийн санхүүд мэдэгдэхүйц их нөлөөлсөн гэжээ. (Эмнэлгийн санхүүд тушаасан мөнгөн дүн гэр бүлийн санхүүд хэр нөлөөлснийг дүрс 60-аас харна уу) (Эмч, сувилагчид өгсөн зүйлийн зардал гэр бүлийн санхүүд нөлөөлснийг дүрс 61-ээс харна уу)

Нийт эмчилгээний зардал 200000 орчим төгрөг болсон. Гэр бүлийн санхүүд тодорхой хэмжээнд нөлөөлж байсан. Гэхдээ ах дүү хамаатан садны тусламж дэмжлэг байсан болохоор тал талаасаа цугларсан мөнгөөр эмчилгээний зардлаа хийсэн дээ.

Иргэн С-ийн ярилцлагаас ЭХЭМҮТ

Дүрс 53. Үйлчлүүлэгчээс өгч буй бэлэг эмч, сувилагчийн хувийн амьдралд хэр их нөлөөтэй байдаг вэ?




Эмч, сувилагчдад үйлчлүүлэгчээс өгч буй бэлэг сэлт, мөнгө хувийн амьдралд нь огт нөлөөлдөггүй гэж эмч сувилагчдын 81 хувь нь хариулсан байна. Үйлчлүүлэгчээс өгч буй бэлэг сэлт, мөнгө эмч, сувилагчдын амьдралд нөлөөлөхгүй байгаа ч үйлчлүүлэгчдийн 68 хувьд нь энэ зардал хүндрэл учруулж байна гэжээ.

## 8. АХ ДҮҮ, ТАНИЛ ТАЛААРАА ДАВУУ ҮЙЛЧЛЭХ

Энэ бүлэгт судалгаанд оролцогчид ах дүү, танил тал буюу нийгмийн сүлжээгээ ашиглан эрүүл мэндийн байгууллагад хандаж байгаа эсэхийг тодруулна.

Дүрс 54. Ах дүү, танил талаа ашиглан бусдаас давуу байдлаар үйлчлэх тохиолдол аль шатлалд илүү байдаг вэ?



Ах дүү, танил талаа ашиглаж, давуу байдалтайгаар үйлчилгээ үзүүлэх тохиолдол 3-р шатлалын эмнэлгүүдэд илүү ажиглагддаг гэж үйлчлүүлэгчдийн 60,1 хувь, эмч сувилагчдын 63,5 хувь нь үзжээ.

Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 3-р шатлалын эмнэлгүүдэд ажиллаж буй эмч, сувилагчид ах дүү танил талдаа тэдний гуйлтаар бусад үйлчлүүлэгчдээс давуу байдал олгож, үйлчилгээ үзүүлдэг явдал их байна.


Дүрс 55. Үйлчлүүлэгч та эмчилгээ, үйлчилгээ авахдаа эмнэлэгт ажилладаг өөрийн хамаатан садан, танил тал найз нөхдийн туслалцаа авдаг уу?



Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдийн 53 хувь нь эмчилгээ, үйлчилгээ авахдаа тодорхой хэмжээгээр ах дүү, танил талаараа дамжуулан үйлчлүүлдэг гэж хариулжээ. Үүнээс 9 хувь нь шаардлага гарсан тохиолдол бүртээ эмнэлэгт ажилладаг танил талдаа ханддаг гэсэн.

Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдийн 47 хувь нь эмнэлгийн байгууллагаар үйлчилгээ авахдаа танил тал, найз нөхдөөсөө туслалцаа огт авдаггүй, авч үзээгүй байна.

*Дүрс 56. Эмч, сувилагч та өөрийн гэр бүл, найз нөхөд, танил, хамт ажиллагсдын гуйлтаар тэдэнд, эсвэл тэдний зуучилсан бусад хүмүүст үйлчилгээ үзүүлэх тохиолдол гардаг уу?*



Судалгаанд оролцсон эмч, сувилагч нарын 81 хувь нь гэр бүл болон танил талын гуйлтаар үйлчилгээ үзүүлэх тохиолдол байдаг гэж хариулсан, үүнээс 7 хувьд нь өдөр тутам тохиолддог байна.

Эмч, сувилагчийн 19 хувь буюу 5 эмч, сувилагч тутмын нэгд нь тийм тохиолдол огт гардаггүй байна. Үүнийг аль төрлийн эмч, сувилагчид их тохиолдог гэдгийг дараах дүрс харуулав.

## ДҮГНЭЛТ

### Ажиглалт ба хандлага

- Нийт судалгаанд оролцогсдын ажиглалтаар 3-р шатлалын эмнэлэгт мөнгө, бэлэг сэлт өгөх тохиолдол түгээмэл байна. Тэр дундаа судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн 86,9 хувь нь, эмч сувилагчдын 67 хувь нь бэлэн мөнгө өгөх явдал ажиглагддаг гэжээ.
- Үйлчлүүлэгчдийн 55,6 хувь нь эмч, сувилагчид бэлэн мөнгө өгөх тохиолдол ажиглагддаг гэсэн бол эмч сувилагчдын 55,2 хувь нь набор, вино, шоколад өгч байгаа нь ажиглагддаг гэжээ.
- Судалгаанд оролцсон эмч, сувилагчдын 84 хувь, үйлчлүүлэгчдийн 83 хувь нь эмч, сувилагчид бэлэн мөнгө өгөх нь байж болохгүй зүйл гэж үзсэн. Гэхдээ үйлчлүүлэгчдийн зүгээс баярлаж талархсан сэтгэлээ илэрхийлэхдээ бэлэг сэлт өгөх нь байж болох зүйл гэж судалгаанд оролцогчдын 66,5 хувь нь хариулсан нь ийм тохиолдолд эергээр хандаж байгааг харуулж байна.
- Судалгаанд оролцогчид бэлэг сэлт, мөнгө өгөх явдлыг цаашид жишиг болгохыг зөвшөөрөхгүй байгаа нь судалгааны үр дүнгээр нотлогдож байна. Үүнийг эмч, сувилагчид ч мөн хүлээн зөвшөөрч байв.


### Үйлчлүүлэгчийн хувийн туршлага

- Нийт үйлчлүүлэгчийн 55 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд эмч, сувилагчид ямар нэг хэлбэрээр бэлэг сэлт, мөнгө өгсөн явдал түгээмэл үзэгдэл болсныг хэлж байгаа бөгөөд тэдний 70,6 хувь нь эмчид, 27,2 хувь нь сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгчээ.
- Бэлэг сэлт, мөнгө илүү их өгсөн эмнэлгүүд нь 3-р шатлалын эмнэлгүүд, дараа нь амаржих газрууд бусдаасаа өндөр байна. Энэ нь мэс засал, төрөх зэрэг үйлчилгээтэй холбоотой байна. Харин өрхийн эмнэлгүүдэд бэлэг сэлт, мөнгө өгөх тохиолдол хамгийн бага байна.
- Эмч, сувилагчид өгч буй зүйлийн гол төрөл нь бэлэн мөнгө (69.7%) байна. Набор, вино, чихэр зэрэг жижиг зүйлсийг (22.9%) гол төлөв 1 удаа өгч байна. Гэхдээ үйлчлүүлэгчийн кейсээс харахад ихэнх тохиолдолд нэг удаагийн бэлэг сэлт, мөнгийг тухайн үйлчилгээг үзүүлж буй баг, хамт олонд (хагалгааны гэх мэт) хуваан өгдөг байна.
- Эмч болон сувилагчийн авч буй бэлгийн өртөг ялгаатай байгаа бөгөөд сувилагчид өгч буй бэлгийн дундаж өртөг эмчийнхээс 2 дахин бага байна. Эмчид өгч буй бэлгийн өртөг дунджаар 121905 төгрөг байгаа бол сувилагчид өгч буй бэлгийн дундаж өртөг 57612 төгрөг байна.


|   |  |
|---|--|
| <p><b>Эмч, сувилагчийн хувийн туршлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Судалгаанд хамрагдсан нийт эмч нарын 66 хувь нь сүүлийн нэг жилийн хугацаанд үйлчлүүлэгчээс ямар нэгэн зүйл авсан. Үүнээс 33,3 хувь нь сард 1-2 удаа ямар нэгэн зүйл үйлчлүүлэгчээс авдаг гэж хариулжээ.</li> <li>• Сүүлийн нэг жилийн хугацаанд ямар нэгэн зүйл авсан гэж хариулсан эмч, сувилагч нарын хамгийн сүүлийн туршлагаас үзэхэд тэд ихэвчлэн набор, вино, шоколад гэх мэт жижиг сажиг бэлэг сэлт авсан гэж хариулсан байна. Тухайн бэлэг өртгийн хувьд 25000 хүртэл үнэтэй байдаг гэж дийлэнх нь хариулсан.</li> </ul> | <p><b>Шалтгаан нөхцөл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Бэлэг сэлт, мөнгө өгөх санаачлагын дийлэнхийг үйлчлүүлэгчид өөрсдөө гаргадаг. Үйлчилгээ авахаас өмнөх шатанд бэлэг сэлт, мөнгө өгч буй шалтгаан нь үйлчлүүлэгчид өөртөө илүү сайн үйлчилгээ авахын тулд байгаа бол үйлчилгээ авсны дараа бэлэг сэлт, мөнгө өгч буй шалтгааны дийлэнх нь үйлчлүүлэгчид талархсан сэтгэлээ илэрхийлж буйн илрэл байна.</li> <li>• Бэлэг сэлт, мөнгө өгсний дараа эмч, сувилагчийн харьцаа, хандлага, үзлэг хяналт илүү сайжирдаг гэж үйлчлүүлэгчид үзсэн. Тиймээс бэлэг сэлт, мөнгө өгөх нь илүү сайн үйлчилгээ авахад нөлөөлдөг гэж дүгнэж болохоор байна.</li> <li>• Судалгаанд оролцсон эмч, сувилагч нар үйлчлүүлэгчээс өгч буй бэлэг сэлт, мөнгөний шалтгаан, нөхцөл байдлыг үйлчлүүлэгчид үйлчилгээ үзүүлсэн эмч, сувилагчдаа баярлаад ямар нэгэн бэлэг сэлт өгдөг, харин эмч, сувилагч нар тухайн үйлчлүүлэгчийн сэтгэлийг гомдоохгүйн тулд авахаас өөр аргагүй байдалд хүрдэг гэж үздэг байна.</li> </ul> |
| <p><b>Санхүүгийн нөлөөлөл</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Үйлчлүүлэгчид эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхдээ төлсөн нийт зардал нь тэдний өрхийн санхүүд мэдэгдэхүйц нөлөөлдөг буюу их хүндрэл учруулдаг гэж үйлчлүүлэгчдийн 32 хувь нь хариулсан.</li> </ul>   | <p><b>Ах дүү танил талаа ашиглах</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Судалгаанд оролцсон үйлчлүүлэгчдийн дийлэнх нь эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхдээ ах дүү, танил талаасаа туслалцаа авдаг, эмч, сувилагч нарын дийлэнх нь танил талын гуйлтаар үйлчилгээ үзүүлдэг байна.</li> <li>• Ах дүү, танил талаа ашиглан үйлчлүүлэх явдал 3-р шатлалын эмнэлэгт илүү байдаг гэдэг дээр үйлчлүүлэгч, эмч, сувилагч нар санал нийлж байна.</li> </ul>   |

## ХАВСРАЛТ 1


Дүрс 57. Таны ажигласнаар энэ эмнэлэгт бэлэг сэлт, мөнгө авах тохиолдол хэр түгээмэл байдаг вэ? (үйлчлүүлэгчийн хариулт)




Дүрс 58. Эмч, сувилагч нарт өгсөн зүйлийн ангилал



## Дүрс 59. Үйлчлүүлэгч ямар үйлчилгээ авахдаа юу өгдөг вэ?




## Дүрс 60. Эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой гарсан зардал үйлчлүүлэгчийн гэр бүлийн санхүүд хэрхэн нөлөөлдөг болох






Дүрс 61. Эмч, сувилагчид өгсөн зүйлийн зардал үйлчлүүлэгчийн гэр бүлийн санхүүд хэрхэн нөлөөлдөг болох




Дүрс 62. Үйлчлүүлэгч эмнэлгийн үйлчилгээ авахдаа бэлэг сэлт, мөнгө өгсөн шалтгаан




Дүрс 63. Эмч, сувилагчийн бэлэг, мөнгө авсан давтамжийг мэргэшсэн мэргэжлээр нь харьцуулсан байдал




Дүрс 64. Эмчид өгч буй зүйлийн өртөг хэмжээ




Дүрс 65. Сувилагчид өгч буй зүйлийн өртөг хэмжээ




Дүрс 66. Аль шатлалын эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгийг ямар давтамжтайгаар авч байна вэ?



## Дүрс 67. Аль шатлалын эмнэлэгт юу өгч байна вэ?



## Дүрс 68. Аль шатлалын эмнэлэгт юу авч байна вэ?



## ХАВСРАЛТ 2

Үйлчлүүлэгчийн асуумж



### ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭН ДЭХ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Зөвшөөрлийн хуудас

Асуумжийн код:

**Асуумжийн зорилго:**

Энэхүү санал асуулгыг “Хараат Бус Судалгааны Хүрээлэн”-ээс явуулж байгаа болно. Олон нийтийн дунд эмч эмнэлгийн ажилтнууд бэлэг сэлт, мөнгө авдаг талаар яригддаг. Энэ талаар үнэн бодит мэдээллийг эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэгчдээс авах, бусад шалтгаан нөхцлийг тодорхойлох зорилгоор энэ судалгааг ЭМЯ болон Нийслэлийн эрүүл мэндийн газрын зөвшөөрөлтэйгээр явуулж байна

**Судалгааг хэрхэн явуулах заавар:**

Хэрэв та энэ судалгаанд оролцохыг зөвшөөрвөл бид танд эрүүл мэндийн үйлчилгээний чанар, ил тод байдлын өнөөгийн бодит байдалтай холбоотой асуулт бүхий асуумжийг асууна. Асуумжид оролцоход ойролцоогоор 10-15 минут зарцуулагдах бөгөөд хэрэгцээтэй, эсвэл эргэлзээтэй асуулт дээр манай ажилтан танд туслах бөгөөд та хүссэн үедээ түүнээс тусламж авах боломжтой.

**Мэдээллийн нууцлал болон сайн дурын оролцооны батламж:**

Таны хариултын нууцыг судалгааны ажилтнууд Монгол улсын “Статистикийн тухай”, “Хувь хүний нууцын тухай” хуулиудын дагуу бусдад задруулахгүйгээр чандлан хадгална.

Түүнчлэн энэхүү судалгааны үр дүнг судалгааны зорилгоос бусдаар ашиглахгүй бөгөөд, судалгааны үр дүнд таны нэр, нас, хүйс болоод хувийн ямар нэг мэдээллийг дурдахгүй болно.

Та энэхүү асуумжид үнэн зөв, бүрэн гүйцэд хариулах хэрэгтэй бөгөөд мэдээллийн нууцыг бид чандлан хадгална. (Би энэ судалгааны талаарх мэдээллийг уншиж танилцлаа. Энэ судалгааны зорилгын талаар асуух зүйлээ би бүрэн асуусан бөгөөд миний асуусан асуултад хангалттай хариулсан. Тиймээс би энэ судалгаанд сайн дураараа оролцож, асуумжид үнэн зөв хариулахаа баталж байна.)

Та болон таны ойр дотны хүн тус /зорилтот эмнэлэг/ эмнэлгээр үйлчлүүлж байна уу?

1. Тийм (би өөрөө)
2. Тийм (эхнэр нөхөр, хүүхэд, төрсөн ах эгч, дүү, аав ээж, эмээ өвөө)
3. Үгүй (Асуумжийг зогсоох)

Огноо: он \_\_\_\_ сар \_\_\_\_ өдөр \_\_\_\_

Судлаачийн код: [\_\_\_\_|\_\_\_\_]

|                              |                                     |
|------------------------------|-------------------------------------|
| Судалгааны цэг<br>[_____]    | Судалгааны цэгийн код:<br>[_____]   |
| ТаТасаг /Кабинет/<br>[_____] | Аль шатлалын эмнэлэг вэ?<br>[_____] |

### НЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

|    |  |  |
|----|--|--|
| 1. | Та хэдэн настай вэ?  | Нас [____ ____]  |
| 2. | Таны хүйс:   | 1. Эрэгтэй<br>2. Эмэгтэй   |
| 3. | Та хаанаас ирж үйлчлүүлж байгаа вэ? (Орон нутгаас ирж үйлчлүүлж байгаа бол аймгийг нь тодорхой бичнэ.) | 1. Нийслэл<br>2. Аймаг /_____ /<br>3. Сум, хөдөө орон нутаг /_____ /   |
| 4. | Таны албан боловсролын дээдтүвшин ямар вэ?   | 1. Боловсролгүй<br>2. Бага /3/4 анги/<br>3. Суурь /8/9 анги/<br>4. Бүрэн дунд /10/11/12 анги/<br>5. Техник болон мэргэжлийн дунд МСҮТ)<br>6. Тусгай мэргэжлийн дунд(коллеж)<br>7. Дипломын болон бакалавр<br>8. Магистр<br>9. Доктор |

ЭН.МН  
СУДАЛГААНЫ САН

|          |   |  |
|----------|---|--|
| 5.<br>6. | 1. Таны ажил эрхлэлтийн байдал (Цалин хөлстэй ажиллагч бол төрийн эсвэл хувийн хэвшил алинд нь ажилладагийг дугуйлна) | 1.1 Цалин хөлстэй ажиллагч<br>1.1.1. Төрийн байгууллага<br>1.1.2. Хувийн хэвшил<br>1.2 Ажил олгогч<br>1.3 Хувиараа хөдөлмөр эрхлэгч<br>1.4 Нөхөрлөл, хоршооны гишүүн<br>1.5 Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч<br>1.6 Бусад _____        |
|          | 2. Ажил эрхэлдэггүй бол шалтгаан?   | 2.1 Суралцагч<br>2.2 Тэтгэвэрт<br>2.3 Хөдөлмөр эрхлэх чадваргүй<br>2.4 Гэрийн ажилтан<br>2.5 Тохирох ажил олдохгүй<br>2.6 Бусад _____  |
| 7.       | Өрхийн гишүүдийн тоо  | [ _____ ]  |
| 8.       | Таны сарын цэвэр орлого хэд вэ?   | [ _____ ]  |
| 9.       | Танай өрхийн сарын дундаж орлого хэд вэ?  | [ _____ ]  |
| 10.      | Танай өрхийн орлого амьдралд тань хэр хүрэлцдэг вэ?   | 1. Өдөр тутмын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй<br>2. Өдөр тутмын ойр зуурын хэрэгцээндээ л хүрдэг<br>3. Зайлшгүй хэрэгцээтэй зүйлсээ авахад хүрэлцдэг<br>4. Тэдгээрээс гадна үнэ цэнэтэй зүйлийг ч авчихдаг<br>5. Хүссэн зүйлээ авч, илүүчилж хуримтлуулж чаддаг |

11. Таны үйлчилгээ авсан хэлбэр?

1. Амбулаторын тусламж, зөвлөгөө, үйлчилгээ (чих, хамар, хоолой, харшил, мэдрэл гэх мэт нарийн мэргэжлийн үзлэг)
2. Оношилгоо (бүх төрлийн шинжилгээ хамаарна)
3. Эмнэлэгт хэвтэж эмчилгээ, тусламж үйлчилгээ авсан (төрөх, мэс засал, дотрын тасгийн хэвтэн эмчилгээ гэх мэт)
4. Сувилахуйн тусламж үйлчилгээ (хөдөлгөөн засал, сэргээн засал гэх мэт)

12. Танд ажиглагдаж байгаагаар аль шатлалын эмнэлэгт дараах зүйлүүд тохиолддог вэ? /Мөр бүрт хариулна уу?/

| № | Төрөл   | I шатлал | II шатлал | III шатлал | Мэдэхгүй |
|---|---|----------|-----------|------------|----------|
| 1 | Эмч, сувилагчийг үдийн болон оройн хоолоор дайлах тохиолдол байдаг. | 1        | 2         | 3          | 4        |
| 2 | Эмч, сувилагчид бяцхан гар цайлгах эд зүйлс өгөх тохиолдол байдаг   | 1        | 2         | 3          | 4        |
| 3 | Эмч, сувилагчид бэлэн мөнгө өгөх тохиолдол байдаг                   | 1        | 2         | 3          | 4        |
| 4 | Ах дүү, танил талаа ашиглаж үйлчлүүлэх тохиолдол байдаг             | 1        | 2         | 3          | 4        |
| 5 | Бусад _____   | 1        | 2         | 3          | 4        |

13. Таны бодлоор дараах зүйлүүд эрүүл мэндийн салбарт хэр зэрэг түгээмэл байдаг вэ? (Мөр бүрт хариулна уу)

| № | Төрөл  | Тун их | Нийтлэг | Цөөн | Огт үгүй | Мэдэхгүй |
|---|--|--------|---------|------|----------|----------|
| 1 | Эмч эмнэлгийн ажилтныг хоолонд урьж, бяцхан гар цайлгах              | 1      | 2       | 3    | 4        | 5        |
| 2 | Эмч эмнэлгийн ажилтанд томоохон эд зүйл, нилээд хэмжээний мөнгө өгөх | 1      | 2       | 3    | 4        | 5        |
| 3 | Ах дүү, танил талаа ашиглаж үйлчлүүлэх                               | 1      | 2       | 3    | 4        | 5        |
| 4 | Бусад _____  | 1      | 2       | 3    | 4        | 5        |

14. Таны ажигласнаар хамгийн нийтлэг хэлбэр нь юу байна вэ?(1-ээс бусдад нь дэлгэрүүлж бичнэ үү. 2 хүртэлх хариултыг сонгож болно. 1 дээш хариулт өгсөн тохиолдолд эрэмбэлнэ үү. Хамгийн чухал бол "1" гэж дугаарлана.)

1. Бэлэн мөнгө
2. Өөр бусад үйлчилгээний эрх, тасалбар \_\_\_\_\_
3. Бэлэг дурсгалын эд зүйлс \_\_\_\_\_



4. Өдрийн болон оройн хоол \_\_\_\_\_
5. Набор, вино, шоколад гэх мэт жижиг \_\_\_\_\_
6. Бусад \_\_\_\_\_
15. Таны ажигласнаар энэ эмнэлэгт эмч, эмнэлгийн ажилтанд бэлэг сэлт, мөнгө өгөх явдал хэр их байна вэ?
  1. Их байна
  2. Нэлээд бий
  3. Бага зэрэг байна
  4. Тийм зүйл бараг байхгүй
  5. Бусад \_\_\_\_\_
16. Эрүүл мэндийн салбарт эмч, эмнэлгийн ажилтнуудад бэлэг сэлт, мөнгө өгөх, танил талаараа давуу үйлчлэх нь зөв үү?
  1. Зөв
  2. Буруу
17. Та дараах ойлголтуудтай санал нийлэх үү?

| № | Бодомж   | Тийм | Үгүй |
|---|--|------|------|
| 1 | Эмч, сувилагчид бэлэг өгөх нь байж болох зүйл                                      | 1    | 2    |
| 2 | Эмч, сувилагчид мөнгө өгөх нь байж болох зүйл                                      | 1    | 2    |
| 3 | Бэлэг сэлт, мөнгө өгсөнөөр эмч, сувилагч нарын зан харьцаа, үйлчилгээ сайжирдаг    | 1    | 2    |
| 4 | Эмч, сувилагч нарын цалин бага учраас бэлэг сэлт, мөнгө авах шалтгаан болдог       | 1    | 2    |
| 5 | Үйлчлүүлэгчид их бага хэмжээгээр өгөх тусам эмч, сувилагч нар авах зуршилтай болно | 1    | 2    |
| 6 | Бэлэг сэлт, мөнгө өгч чадахгүй байгаа хүмүүс тааруу үйлчилгээ авдаг                | 1    | 2    |
| 7 | Бэлэг сэлт, мөнгө авч байгаа нь эмч нарын ёс суртахуун, хүн чанар доройтсны илрэл  | 1    | 2    |

18. Та эмчилгээ, үйлчилгээ авахдаа эмнэлэгт ажилладаг өөрийн хамаатан садан, танил тал, найз нөхдийн туслалцаа авдаг уу?
  1. Эмчилгээ, үйлчилгээний хэрэгцээ шаардлага гарах бүрт
  2. Эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой саад бэрхшээл гарсан үед л туслалцаа авдаг
  3. Танил тал, найз нөхөдөөсөө туслалцаа авдаггүй.

## ХОЁР. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТУРШЛАГА

19. Сүүлийн 1 жилийн хугацаанд та болон таны ойр дотныхон үйлчилгээ авахтай холбогдуулж эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгөх тохиолдол гарсан уу?
1. Тийм (би өөрөө)
  2. Тийм (эхнэр нөхөр, хүүхэд, төрсөн ах эгч, дүү, аав ээж, эмээ өвөө)
  3. Үгүй (29-р асуултаас үргэлжлүүлэх)
20. Хэрэв тийм бол аль эмнэлэгт вэ?
1. Энэ эмнэлэгт (Судалгаа авч буй эмнэлгийнхээ нэрийг бичнэ үү)  
\_\_\_\_\_
  2. Өөр эмнэлэгт (Аль эмнэлэг болохыг дурдах) \_\_\_\_\_
21. Ямар төрлийн үйлчилгээ авахтай холбоотойгоор тухайн зүйлийг өгсөн бэ? /мэс засалд орсон, физик эмчилгээ хийлгэсэн, ороолт боолт, төрөлт гэх мэт нарийвчлан бичнэ/ \_\_\_\_\_
22. Үйлчилгээний аль шатанд өгсөн бэ? /Олон сонголттой/
1. Үйлчилгээ авахаас өмнө/22-р асуулт руу шилжинэ үү/
  2. Үйлчилгээ бүрэн авсныхаа дараа /23-р асуулт руу шилжинэ үү /
  3. Аль аль шатанд нь /22 болон 23-р асуулт асуух/
  4. Бусад. \_\_\_\_\_
23. Үйлчилгээ авахаас өмнө өгөх болсон шалтгаан юу вэ?  
(2 хүртэлх хариулыг сонгож болно. 1 дээш хариулт өгсөн тохиолдолд эрэмбэлнэ үү. Хамгийн чухал бол "1" гэж дугаарлана.)
1. Эмнэлгийн ачаалал, дараалал их байсан
  2. Эмчилгээ, үйлчилгээ тодорхой шалтгаангүйгээр хийгдэхгүй байсан
  3. Мөнгө, ямар нэг зүйл хүлээж байгаагаар эмч, сувилагч яриа, зан байдал, үйл хөдлөлөөрөө шууд бусаар илэрхийлсэн /тухайлбал яаж? \_\_\_\_\_/
  4. Өгөх хэрэгтэй гэдгийг эмч, сувилагч шууд хэлсэн
  5. Бусад хүмүүс өгсөн болохоор адилхан өгсөн
  6. Эмч, сувилагчийн анхаарлыг хандуулж, илүү сайн үйлчилгээ авахын тулд зөвхөн өөрийн санаачлагаар өгсөн
  7. Бусад \_\_\_\_\_
24. Үйлчилгээ бүрэн авсныхаа дараа өгөх болсон шалтгаан юу вэ?  
(2 хүртэлх хариулыг сонгож болно. 1 дээш хариулт өгсөн тохиолдолд эрэмбэлнэ үү. Хамгийн чухал бол "1" гэж дугаарлана.)

1. Эмчилгээ үйлчилгээ сайн, амжилттай болсон болохоор баярлаад өөрсдийн санаачлагаар өгсөн
  2. Мөнгө, ямар нэг зүйл хүлээж байгаагаа эмч, сувилагч яриа, зан байдал, үйл хөдлөлөөрөө шууд бусаар илэрхийлсэн /тухайлбал яаж? \_\_\_\_\_/
  3. Өгөх хэрэгтэй гэдгийг шууд хэлсэн
  4. Дараа үйлчлүүлж магадгүй учраас ирээдүйгээ бодож өгсөн
  5. Бусад \_\_\_\_\_
25. Тухайн зүйлээ хэнд өгсөн бэ?(2 хүртэлх хариултыг сонгож болно. 1 дээш хариулт өгсөн тохиолдолд эрэмбэлнэ үү. Хамгийн чухал бол "1" гэж дугаарлана.)
1. Үйлчилгээ үзүүлсэн эмчид өөрт нь
  2. Үйлчилгээ үзүүлсэн сувилагчид өөрт нь
  3. Бага эмчид
  4. Асрагч
  5. Лаборант, техникч
  6. Эмнэлгийн удирдлага, захиргааны ажилтанд
  7. Бусад \_\_\_\_\_
26. Таны өгсөн зүйл юу байсан бэ? (1-ээс бусдад нь дэлгэрүүлж бичнэ үү. 2 хүртэлх хариултыг сонгож болно. 1 дээш хариулт өгсөн тохиолдолд эрэмбэлнэ үү. Өгсөн хамгийн гол зүйл бол 1 гэж дугаарлана.)
1. Бэлэн мөнгө
  2. Өөр бусад үйлчилгээний эрх, тасалбар \_\_\_\_\_
  3. Бэлэг дурсгалын эд зүйлс \_\_\_\_\_
  4. Өдрийн болон оройн хоол \_\_\_\_\_
  5. Набор, вино, шоколад гэх мэт жижиг бэлэг \_\_\_\_\_
  6. Бусад \_\_\_\_\_
27. Таны эмч, сувилагчид өгсөн зүйл дунджаар ямар өртөгтэй байсан вэ? (Хамгийн сүүлчийн тохиолдлыг авна. Бусад гэдэг дээр 24-р асуултын 3-7-р хариултанд заасан хүмүүсийг оруулна. 1,2,3-р хариултаас бодож нийт дүнг заавал бөглөнө.)

| 1. Эмчид /Төгрөг/ | 2.Сувилагчид /Төгрөг/ | 3.Бусад /Төгрөг/ | 4.Нийт /Төгрөг/ |
|-------------------|-----------------------|------------------|-----------------|
|                   |                       |                  |                 |

28. Та тухайн үйлчилгээг авахдаа хэдэн удаа өгөх хэрэгтэй болсон бэ?
1. 1 удаа
  2. 2-3 удаа
  3. 4-5 удаа
  4. 5-с дээш удаа
29. Эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгсний дараа юу өөрчлөгдсөн бэ?  
(3 хүртэлх хариулт сонгож болно.)
1. Эм тариа нэмэгдсэн
  2. Эмч, сувилагчийн харьцаа хандлага сайжирсан
  3. Үзлэг, хяналт сайжирсан
  4. Чирэгдэл арилсан
  5. Ор хоног сунгасан
  6. Өвчтөний сэтгэл санаа дээрдсэн
  7. Хүсч хүлээсэн хэмжээнд өөрчлөлт гараагүй
  8. Бусад \_\_\_\_\_
30. Та үйлчилгээ авах үедээ эмнэлгийн байгууллагын санхүүд хэдэн төгрөг тушаасан бэ?  
(\_\_\_\_\_ төгрөг)
31. Эмчилгээ үйлчилгээ авахтай холбогдон гарсан нийт зардал таны эсвэл танай гэр бүлийн санхүүд хэр их нөлөөлсөн бэ?(18 болон 29-р асуултад хоёуланд нь үгүй гэж хариулсан бол энэ асуултыг алгасана уу.)
1. Их хүндрэл учруулсан
  2. Мэдэгдэхүйц нөлөөлсөн
  3. Бага зэрэг нөлөөлсөн
  4. Огт асуудал байгаагүй
32. Эмч, сувилагчид бэлэг сэлт, мөнгө өгөх явдал цаашид (ирээдүйд) жишиг болохыг та зөвшөөрөх үү?
1. Тийм
  2. Үгүй
33. Энэ байдлыг өөрчлөхийн тулд юу хийх хэрэгтэй гэж та бодож байна вэ?  
\_\_\_\_\_

Утасны дугаар \_\_\_\_\_

Танд талархлаа

**ЧАНАРЫН ХЯНАЛТЫН ХЭСЭГ:**

|  |                                      |
|--|--------------------------------------|
| Багийн ахлагчийн гарын үсэг: _____     | Огноо: ____ он<br>____ сар ____ өдөр |
| Утсаар шалгагчийн гарын үсэг: _____    | Огноо: ____ он<br>____ сар ____ өдөр |
| Мэдээлэл оруулагчийн гарын үсэг: _____ | Огноо: ____ он<br>____ сар ____ өдөр |
| Мэдээлэл тулгагчийн гарын үсэг: _____  | Огноо: ____ он<br>____ сар ____ өдөр |

Эмч, сувилагчийн асуумж

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭН ДЭХ АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

### Зөвшөөрлийн хуудас

Асуумжийн код: □□□□

#### Асуумжийн зорилго:

Энэхүү санал асуулгыг “Хараат Бус Судалгааны Хүрээлэн”-ээс явуулж байгаа болно. Олон нийтийн дунд эмч эмнэлгийн ажилтнууд бэлэг сэлт, мөнгө авдаг талаар яригддаг. Энэ талаар үнэн бодитой мэдээллийг мэргэжлийн хүмүүсээс авах, бусад шалтгаан нөхцлийг тодорхойлох зорилгоор энэ судалгааг ЭМЯ болон Нийслэлийн эрүүл мэндийн газрын зөвшөөрөлтэйгээр явуулж байна

Таны зөвшөөрөлтэйгээр бид судалгааны сэдвийн хүрээнд асуулт асуух бөгөөд асуумж ойролцоогоор 10-15 минут зарцуулагдана.

#### Мэдээллийн нууцлал болон сайн дурын оролцооны батламж:

Таны хариултын нууцыг судалгааны ажилтнууд Монгол улсын “Статистикийн тухай”, “Хувь хүний нууцын тухай” хуулиудын дагуу бусдад задруулахгүйгээр чандлан хадгална.

Түүнчлэн энэхүү судалгааны үр дүнг судалгааны зорилгоос бусдаар ашиглахгүй бөгөөд, судалгааны үр дүнд таны нэр, нас, хүйс болоод хувийн ямар нэг мэдээлэл дурдагдахгүй болно.

(Би энэ судалгааны талаарх мэдээллийг уншиж танилцлаа. Энэ судалгааны зорилгын талаар асуух зүйлээ би бүрэн асуусан бөгөөд миний асуусан асуултад хангалттай хариулсан. Тиймээс би энэ судалгаанд сайн дураараа оролцож, асуумжид үнэн зөв хариулахаа баталж байна.)

#### Та эрүүл мэндийн байгууллагад 1-ээс дээш жил ажилласан уу?

4. Тийм
5. Үгүй

Огноо: он \_\_\_\_ сар \_\_\_\_ өдөр \_\_\_\_

Судлаачийн код: [\_\_\_\_|\_\_\_\_]

|                           |                                   |
|---------------------------|-----------------------------------|
| Судалгааны цэг<br>[_____] | Судалгааны цэгийн код:<br>[_____] |
|---------------------------|-----------------------------------|

|                           |                                     |
|---------------------------|-------------------------------------|
| Тасаг /Кабинет<br>[_____] | Аль шатлалын эмнэлэг вэ?<br>[_____] |
|---------------------------|-------------------------------------|

## НЭГ. СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИЙН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

|     |  |   |
|-----|--|---|
| 1.  | Та хэдэн настай вэ?                            | Нас [___ ___]   |
| 2.  | Таны хүйс:                                     | 3. Эрэгтэй<br>4. Эмэгтэй  |
| 3.  | Таны албан тушаал?                             | 1. Эмч<br>2. Сувилагч   |
| 4.  | Таны албан боловсролын дээдтүвшин ямар вэ?     | 10. Техник болон мэргэжлийн дунд (МСҮТ)<br>11. Тусгай мэргэжлийн дунд(коллеж)<br>12. Дипломын болон бакалавр<br>13. Магистр<br>14. Доктор   |
| 5.  | Таны мэргэшсэн мэргэшил юу вэ?                 | 1. Ерөнхий мэргэжлийн их эмч<br>2. Нарийн (төрөлжсөн) мэргэжлийн их эмч<br>3. Эх барихуйн мэргэжилтэн<br>4. Яаралтай тусламжийн эмч<br>5. Ерөнхий мэргэжлийн сувилагч<br>6. Нарийн мэргэжлийн сувилагч  |
| 6   | Таны мэргэжлийн зэрэг тань юу вэ ?             | a. Зэрэггүй<br>b. Ахлах зэрэг<br>c. Тэргүүлэх зэрэг<br>d. Зөвлөх зэрэг  |
| 7.  | Өрхийн гишүүдийн тоо                           | [_____]   |
| 8.  | Таны сарын цэвэр орлого хэд вэ?                | [_____]   |
| 9.  | Танай өрхийн сарын дундаж орлого хэд вэ?       | [_____]   |
| 10. | Танай өрхийн орлого амьдралд хэр хүрэлцдэг вэ? | 6. Өдөр тутмын ойр зуурын хэрэгцээнд ч хүрэлцдэггүй<br>7. Өдөр тутмын ойр зуурын хэрэгцээндээ л хүрдэг<br>8. Зайлшгүй хэрэгцээтэй зүйлсээ авахад хүрэлцдэг<br>9. Тэдгээрээс гадна үнэ цэнэтэй зүйлийг ч авчихдаг<br>10. Хүссэн зүйлээ авч, хуримтлуулж чаддаг |

11. Та эмнэлгийн байгууллагад хэдэн жил ажиллаж байна вэ? /4-р хариултанд дэлгэрэнгүй хариулах/

1. 1-3 жил
2. 4-6 жил

3. 7-9 жил
4. 10 ба түүнээс дээш жил / \_\_\_\_\_ /
12. Ажил үүргээ гүйцэтгэх явцад танд тулгарч буй хамгийн бэрхшээлтэй асуудал юу вэ?
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
13. Та өдөрт дунджаар хэдэн хүнд үйлчилдэг вэ?
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
14. Та өдөрт дунджаар хэдэн цаг ажилладаг вэ?
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
15. Танд ажиглагдаж байгаагаар аль шатлалын эмнэлэгт дараах зүйлүүд тохиолддог вэ?

|   |   | I шатлал | II шатлал | III шатлал | Мэдэхгүй |
|---|---|----------|-----------|------------|----------|
| 1 | Эмч, сувилагчийг үдийн болон оройн хоолоор дайлах тохиолдол байдаг. | 1        | 2         | 3          | 4        |
| 2 | Эмч, сувилагчид бяцхан гар цайлгах эд зүйлс өгөх тохиолдол байдаг   | 1        | 2         | 3          | 4        |
| 3 | Эмч, сувилагчид бэлэн мөнгө өгөх тохиолдол байдаг                   | 1        | 2         | 3          | 4        |
| 4 | Ах дүү, танил талаа ашиглаж үйлчлүүлэх тохиолдол байдаг             | 1        | 2         | 3          | 4        |
| 5 | Бусад.....  | 1        | 2         | 3          | 4        |

16. Таны бодлоор дараах зүйлүүд эрүүл мэндийн салбарт хэр зэрэг түгээмэл байдаг вэ? /Мөр бүрт хариулна уу?/

|   |   | Тун их түгээмэл | Нийтлэг тохиолдоно | Цөөн | Огт үгүй | Мэдэхгүй |
|---|---|-----------------|--------------------|------|----------|----------|
| 1 | Эмч эмнэлгийн ажилтныг хоолонд урьж, бяцхан гар цайлгах | 1               | 2                  | 3    | 4        | 5        |



|   |  |   |   |   |   |   |
|---|--|---|---|---|---|---|
| 2 | Эмч эмнэлгийн ажилтанд томоохон эд зүйл, нэлээд хэмжээний мөнгө өгөх | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 3 | Ах дүү, танил талаа ашиглаж үйлчлүүлэх                               | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 4 | Бусад.....<br>.....  | 1 | 2 | 3 | 4 | 5 |

17. Таны ажигласнаар хамгийн нийтлэг хэлбэр нь юу байна вэ? (1-ээс бусдад нь дэлгэрүүлж бичнэ үү. 2 хүртэлх хариултыг сонгож болно. 1 дээш хариулт өгсөн тохиолдолд эрэмбэлнэ үү. Хамгийн чухал бол “1” гэж дугаарлана.)

- a. Бэлэн мөнгө
- b. Өөр бусад үйлчилгээний эрх, тасалбар

\_\_\_\_\_

c. Бэлэг дурсгалын эд зүйлс

\_\_\_\_\_

d. Өдрийн болон оройн хоол

\_\_\_\_\_

e. Набор, вино, шоколад гэх мэт жижиг бэлэг

\_\_\_\_\_

f. Бусад

18. Танай эмнэлэгт үйлчлүүлэгчдээс эмч, сувилагч нарт бэлэг сэлт, мөнгө өгөх явдал хэр их ажиглагддаг вэ?

- a. Их байна
- b. Нилээд бий
- c. Бага зэрэг байна
- d. Тийм зүйл байхгүй

19. Та дараахь ойлголтуудтай санал нийлэх үү?

|   | Бодомж   | Тийм | Үгүй |
|---|--|------|------|
| 1 | Эмч, сувилагчид бэлэг өгөх нь байж болох зүйл              | 1    | 2    |
| 2 | Эмч, сувилагчид мөнгө өгөх нь байж болох зүйл              | 1    | 2    |
| 3 | Үйлчлүүлэгчид чанартай үйлчилгээ авахын тулд өөрсдөө өгдөг | 1    | 2    |

|   |  |   |   |
|---|--|---|---|
| 4 | Эмч сувилагч нарын цалин бага байгаа нь авах шалтгаан болдог                       | 1 | 2 |
| 5 | Өгснийг нь их бага хэмжээгээр аваад байх нь цаашид авах сонирхол төрүүлж болзошгүй | 1 | 2 |
| 6 | Үйлчлүүлэгчээс өгсөн мөнгө, бэлэг сэлт үйлчилгээний чанарт нөлөөлдөг               | 1 | 2 |
| 7 | Мөнгө, шан харамж авах нь ёс суртахуун, хүн чанар доройтсны шинж                   | 1 | 2 |

20. Та өөрийн гэр бүлийн гишүүн, найз нөхөд, танил, хамт ажиллагсдын гуйлтаар тэдэнд эсвэл тэдний зуучилсан бусад хүмүүст үйлчилгээ үзүүлэх тохиолдол гардаг уу?
- Өдөр тутам
  - Долоо хоногт 1-2 удаа
  - Сард 1-2 удаа
  - Хоёр сардаа 1-2 удаа
  - Бусад \_\_\_\_\_

### ХОЁР. ЭМЧ, СУВИЛАГЧИЙН ТУРШЛАГА

Сануулага: Гар дээр ирсэн бэлгийг л тооцно. Тухайн респондентод бэлэг өгөх арга хэлбэрүүдийг оруулна. Сэтгэлийн бэлэг буюу бэлэг сэлт, мөнгөнөөс бусад зүйл үүнд хамаарахгүй болно. Тухайлбал мэндчилгээ явуулах гэх мэт.

21. Таныг үйлчилгээ үзүүлэх явцад үйлчүүлэгч болон түүний ар гэрээс ямар нэг зүйл өгөх, эсвэл бусад байдлаар талархлаа илэрхийлсэн тохиолдол сүүлийн нэг жилийн хугацаанд гарсан уу?
- Тийм /Асуумжийг үргэлжлүүлэх/
  - Үгүй /28-р асуултруу шилжих/
22. Нэг жилийн хугацаанд танд ямар нэг зүйл өгөх тохиолдол хэдэн удаа гарсан бэ?
- Жилдээ 1-2 удаа
  - Жилдээ 3-4 удаа
  - Жилдээ 5 ба түүнээс дээш
  - Сардаа 1-2
  - Сардаа 3-4
  - Сардаа 5 ба түүнээс дээш

- g. Мэдэхгүй
23. Хамгийн сүүлд танд өгсөн зүйл юу байсан бэ? (1-ээс бусдад нь дэлгэрүүлж бичнэ үү. 2 хүртэлх хариултыг сонгож болно. 1 дээш хариулт өгсөн тохиолдолд эрэмбэлнэ үү. Хамгийн чухал бол "1" гэж дугаарлана.)
- a. Бэлэн мөнгө
- b. Өөр бусад үйлчилгээний эрх, тасалбар
- 
- c. Бэлэг дурсгалын эд зүйлс
- 
- d. Өдрийн болон оройн хоол
- 
- e. Набор, вино, шоколад гэх мэт жижиг бэлэг
- 
- f. Бусад
- 
24. Танд өгсөн зүйл дунджаар ямар өртөгтэй байдаг вэ?
- 
- 
25. Үйлчлүүлэгч ямар шалтгаанаар танд дээрх зүйлийг өгсөн гэж та бодож байна?
1. Эмчилгээ үйлчилгээ сайн байсан учраас
2. Өвчтөн, түүний ар гэр баярлаж талархсан учраас
3. Өөртөө буюу өвчтөнд давуу үйлчилгээ авахын тулд
4. Ихэнх үйлчлүүлэгчдийн жишгээр
5. Бусад \_\_\_\_\_
26. Та яагаад үйлчлүүлэгчээс өгсөн зүйлийг авсан вэ?
1. Үйлчлүүлэгчийн сэтгэлийг гомдоохгүйн тулд
2. Угаасаа эмч, сувилагч болгон авдаг учраас
3. Авахгүй байх шалтгаан байхгүй учраас
4. Бусад \_\_\_\_\_
27. Үйлчлүүлэгчээс танд өгч буй зүйл нь таны хувийн амьдралд хэр нөлөөтэй байдаг вэ?
- a. Их нөлөөтэй байдаг
- b. Нөлөөтэй байдаг
- c. Тодорхой хэмжээнд нэмэртэй байдаг

- d. Онцын нөлөө байхгүй
  - e. Огт нөлөөлдөггүй
28. Ирээдүйд үйлчлүүлэгч эмч, сувилагч нарт бэлэг сэлт, мөнгө өгөх явдал цаашид жишиг болохыг та зөвшөөрөх үү ?
- 1. Тийм
  - 2. Үгүй
29. Одоогийн байдлыг өөрчлөхийн тулд юу хийх шаардлагатай вэ?

---

---

---

Утасны дугаар \_\_\_\_\_

Танд талархлаа

## ХАВСРАЛТ 3

### СУДЛАГДСАН БАЙДАЛ

#### 1. Авлигын индексийн 2013 оны судалгааны үр дүнгийн тайлан (2014 он)

**Захиалагч:** Авлигатай тэмцэх газар

**Зорилго:** Авлигын талаар талуудын төсөөлөл болон бодит тоо мэдээлэлд үндэслэн авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгааныг судлах

**Түүвэр:** Тогтмол 6000 нэгж хамруулж ирсэний 4000 нь сум, дүүргийн иргэд, бизнес эрхлэгчид, 2000 төрийн албан хаагчид оролцсон.

**Гол үр дүн:** Шинжээч, олон нийтийн үзсэнээр улс төрийн нөлөө болон ашиг сонирхлын зөрчил их, төрийн албан хаагчдын цалин, орлого бага, эрх зүйн зохицуулалт, хуулийн хэрэгжилт сул байгаа нь Монгол улсад авлига үүсэх хамгийн ихээр нөлөөлж буй шалтгаан болж байна.

#### 2. Төрийн байгууллагын нээлттэй ил тод байдлын мониторинг (2007 он)

**Захиалагч:** АТГ-ын захиалгаар Нээлттэй Нийгэм Форумын санхүүжилтээр Глоб Интернэйшнл ТББ гүйцэтгэв

**Зорилго:** АТГ-аас гаргасан зөвлөмжийн дагуу төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй болгох чиглэлээр төрийн байгууллагад хэрхэн ажиллаж байгаа талаар бодитой мэдээлэлтэй болох, уг мэдээлэлдээ тулгуурлан зөвлөмжийн хэрэгжилтийн түвшин, хэрэгжүүлэхгүй байгаа шалтгаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг илрүүлж төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн ерөнхий зөвлөмж боловсруулах

**Түүвэр:** Ажиглалтын судалгаанд 107 байгууллага, сурвалжлагын судалгаанд 104 албан тушаалтан, 106 ажилтан, төрийн байгууллагаар үйлчлүүлэгч 319 иргэн оролцов.

**Гол үр дүн:** Уг судалгааны эрүүл мэндийн байгууллагад хандсан иргэдийн 20% нь нэмэлт, төлбөр хураамж төлсөн байна. Төлбөр, хураамж төлсөн байгууллагын 4-р байранд эрүүл мэндийн салбар орсон байна.

### 3. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, эмнэлгийн мэргэжилтний байгууллагаас гадуурх ажил эрхлэлт (2013 он)

**Захиалагч:** ЭМЯ

**Зорилго:** Эрүүл мэндийн байгууллагын ил тод байдал, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй хариуцлага, эмнэлгийн мэргэжилтний байгууллагаас гадуурх ажил эрхлэлтийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, зөвлөмж боловсруулах

**Түүвэр:** ЭМЯ-ны харьяа бүх төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, амаржих газрыг зориудаар сонгов. Нийт 1254 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, 683 үйлчлүүлэгчид хамрагдсан.

**Гол үр дүн:** Судалгаанд хамрагдсан эмнэлгийн ажилтны дийлэнх нь ёс зүйн ямар нэг сургалтанд хамрагдсан боловч мэдлэг, хандлага хангалтгүй, эрүүл мэндийн байгууллагад эмнэлгийн ажилтны ёс зүйн чиглэлээр явуулдаг үйл ажиллагаа хангалтгүй. Эмнэлгийн удирдах албан тушаалтнуудад өөрсдийн танил талд илүү эмчилгээ хийх байдал их, санхүүгийн тайлангаа ил тод тавьдаггүй дутагдал түгээмэл байна. Эмнэлгийн мэргэжилтнүүдэд өөрийн мэргэжлээр ажлын бус цагаар, хувийн байгууллагуудад, өөрийн үндсэн ажилтай адил давхар ажил эрхлэх байдал цөөнгүй байна. Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчид гол төлөв аймгийн нэгдсэн эмнэлэгт 34,5 %, УБ хотын 2 дагч шатлалын эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвд 24,7% хувь нь албан бус төлбөр өгчээ.

### 4. Авлигын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг тогтоох судалгаа (2013 он)

**Захиалагч:** АНУ-ын ОУХА-ийн санхүүжилтээр Азийн сан, Сант Марал сан гүйцэтгэв.

**Зорилго:** Иргэдийн авлигатай холбоотой бодит туршлага болон дээд түвшний авлигын талаарх ойлголт, мэдлэгийг тандан судлах

**Түүвэр:** УБ хотын 7 дүүрэг болон 6 аймгийн 21 сумын нийт 1360 өрхөөс ярилцлага авсан.

**Гол үр дүн:** Авлига Монгол Улсад тулгарч буй асуудлын 3-рт орсон хэвээр байна. Судалгаанд оролцогчид авлига ирээдүйд буурна гэж үзэж байна. Газрын алба, бараа үйлчилгээ худалдан авах тендер болон уул уурхай нь авлигалд хамгийн их өртсөн салбар хэвээр байна. Авлигын тархалт Эрүүл мэндийн салбарт 5-аас 3,45 оноотойгоор 12-р байранд жагссан байна.

### 5. Эрүүл мэндийн салбар дахь авлигал ба шудрага ёсны өнөөгийн байдал (2007 он)

**Захиалагч:** НҮБХХ санхүүжилтээр ЭМЯ-ны дэмжлэгтэйгээр МУИС-Социологийн тэнхим “Социологийн Академи” төв гүйцэтгэв.

**Зорилго:** Эрүүл мэндийн салбар дах авлигын тархалт, шалтгаан үр дагаварын өнөөгийн байдлын талаарх олон нийтийн болоод эмч, эмнэлгийг ажилтнуудын ойлголтыг тодруулж үнэлгээ хийх, эрүүл мэндийн салбар дах авлигын орчныг хязгаарлах, шудрага ёсыг хангахад чиглэсэн мэдээллийн санг бүрдүүлэхэд хувь нэмэр болох, эрүүл мэндийн тогтолцоонд буй дутагдалтай асуудлыг онцлон, судалж, чирэгдлийг арилгах, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах боломж, хувилбарыг дэвшүүлэх

**Түүвэр:** Улаанбаатар хотын 306 үйлчлүүлэгч, 78 эмч, эмнэлгийн ажилтан, орон нутгийн 707 үйлчлүүлэгч, 151 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан.

**Гол үр дүн:** Судалгаанд оролцогдсон үйлчлүүлэгчдийн 36% нь албан бус төлбөр байх ёстой гэж үзсэн бол эмч, эмнэлгийн ажилтны 80% нь ямар нэг хэмжээгээр хүлээн зөвшөөрөх ёстой гэж үзсэн байна. Эрүүл мэндийн салбарт албан бус төлбөр байгаа гэж судалгаанд ороцогчсон ихэнх бүлгүүдэд санал эргэцүүлэл давамгайлж байна. Олон нийтийн дунд албан бус төлбөрийг гар цайлгал гэж үзэх үзэл хамгийн их жин дарж байна. Олон нийт болон эмч, эмнэлгийн ажилтнуудын хувьд гар цайлгалт өртгийн хувьд бага буюу 3-30 мянган төгрөгтэй тэнцэх, хүмүүсийн баярласан талархсан сэтгэлээс үүдэлтэй зүйл гэж тодорхойлж байна.

Гар цайлгалт нь хэлбэрийн хувьд хоол, цай, чихэр, печень, бага зэргийнбэлэн мөнгө голчилж байгаа бол орон нутагт айраг цагаа, мах шөл өгөх хэлбэрээр илэрч байна. Эрүүл мэндийн салбарт авлига үүсгэж буй гол шалтгаан нь эмч, эмнэлгийн ажилтны цалин орлого бага, үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал, салбарын хяналт, шалгалт сул, хүнд суртал, чирэгдэл ихтэй, зохицуулах хуулт тогтоомж байхгүй, хүмүүс өгөх ёстой гэдэг хэвшмэл ойлголттой зэрэг болно.

NOTE

---

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**



NOTE

---

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

NOTE

---

**UIH.MN**  
**СУДАЛГААНЫ САН**

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН

**UIH.MN**  
СУДАЛГААНЫ САН